

Элч Нарын Тунхаг

1-р хичээл

Итгэлийн үндсэн
тунхаглалууд

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2014 Гурав Дахь Мянган Үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Библийн бүх эшлэлийг Ариун Библи 2019 (АБ2019), Ариун Бичээс Нийгэмлэг.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

Гурав дахь мянган үйлчлэл нь 1997 онд үүсгэн байгуулагдсан, ашгийн бус, Христитгэлийн Сайнмэдээний үйлчлэл бөгөөд дараах талбаруудад чиглэдэг:

Библийн Боловсролыг. Бүх дэлхийд. Үнэгүйгээр.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.thirdmill.org цахим хуудсаар зочлоорой.

Элч Нарын Тунхаг
Нэгдүгээр Хичээл
Итгэлийн үндсэн тунхаглалууд

Гарчиг

Удиртгал.....	1
ТҮҮХ.....	2
Түүхэн хөгжил.....	2
Зорилго.....	3
Бичвэр	4
Уламжлалт сургаалууд.....	5
Элч нарын тунхаг.....	8
ТОЙМ.....	10
Бурхан.....	10
Гурвал.....	10
Бурханы бодгалиуд.....	12
Чуулган	13
Оролцоо.....	14
Хамгаалалт.....	15
Аврал.....	16
АЧ ХОЛБОГДОЛ.....	18
Үндэс суурь	18
Стандарт.....	19
Учир зүйн үндэс.....	20
Дэлхий дахин.....	21
Шинэ Гэрээ.....	22
Чуулганы түүх.....	23
Өнөө цаг.....	24
Нэгдэл	26
ДҮГНЭЛТ.....	28
ХАМТРАГЧИД.....	29
ҮГСИЙН ТАЙЛБАР	31

Элч Нарын Тунхаг

Нэгдүгээр Хичээл

Итгэлийн үндсэн тунхаглалууд

УДИРТГАЛ

Модыг юу мод болгодог юм бол? Байшинг юу байшин болгодог юм бол, эсвэл хүнийг чухам юу хүн болгодог юм бол гэж та урьд өмнө нь бодож байсан уу? Арай өөрөөр асууж үзье л дээ, мод эсвэл байшин байхын тулд ямар чанарыг агуулсан байх ёстой юм бол? Эдгээр ярвигтай асуултуудыг олон мянган жилийн турш гүн ухаантнууд тунгаасаар ирсэн байдаг. Тэгвэл бид Христитгэлийн теологийг судалж байхдаа үүнтэй төстэй асуултуудтай нүүр тулгардаг. Өнөө цагт “Христитгэлийн” гэх тоо томшгүй сүм чуулган бий болсон ч ихэнх нь олон зүйл дээр санал зөрөлддөг. Тиймээс “Христитгэлийн теологийн хамгийн чухал, үндсэн суурь онол сургаал юу вэ?” гэж асуух шаардлагатай юм.

Мэдээж хэрэг бид энэ асуултыг асуусан учраас хэн нэгэн хүн теологийн маш бага мэдлэгтэй байсан ч аврагдах боломжтой гэдгийг тодорхой болгох нь зүйтэй. Бид Христийг тууштай дагах нь Христитгэгч болоход хангалттай. Мөн үүний зэрэгцээ ямар ч теологийн үзэл санааг “Христитгэлийнх” гэж нэрлэхээсээ өмнө энэ нь хэд хэдэн чухал ойлголтыг агуулж байх ёстой гэдгийг хэлэх нь зөв юм. Сүм чуулганы эхэн үеэс л ашигласаар ирсэн *Элч нарын тунхаг* нь тэдгээр итгэлийн үндсэн гол ойлголтыг агуулсан байдаг.

Энэ хичээл бол Христитгэгчид юунд итгэдэг талаарх бүх хүний сайн мэддэг, газар сайгүй ашиглагддаг хураангуй болох *Элч нарын тунхгийн тухай цуврал хичээлийн маань* эхнийх нь юм. Энэхүү хичээлээ бид “*Итгэлийн үндсэн тунхаглалууд*” гэж нэрлэсэн. Учир нь бид *Элч нарын тунхгийг* өөрсдийгөө “Христитгэгч” гэж үздэг хүн бүрийн тунхаглан итгэх ёстой чухал ойлголтууд буюу онол сургаалын хураангуй гэдэг талаас нь үзэх болно. *Элч нарын тунхаг* нь чуулганы анхны зуунуудад янз бүрийн хэлбэрээр гарч ирж байсан. Харин МЭ 700 онд Латин хэл дээрх стандарт хувилбар нь гарсан байдаг. Орчин цагийн Англи хэлэнд буулгасан хамгийн түгээмэл хэлбэрийг харцгаая:

Би тэнгэр газрыг Бүтээгч,
Төгс хүчит Бурхан Эцэгт итгэдэг.
Ариун Сүнсээр олдож,
Онгон Мариаас мэндэлсэн,
Понти Пилатын дор зовж явсан,
Цовдлогдон нас барж, оршуулагдаад
Үхэгсдийн орон руу яваад,
Гурав дахь өдрөө үхлээс дахин амилсан,
Тэгээд мөнхийн улс руу одож,
Төгс хүчит Бурхан Эцэгийнхээ
Баруун мутарт заларсан,
Тэндээс үхсэн, амьд
Бүх хүнийг шүүхээр ирэх

Түүний цорын ганц Хүү
Бидний Эзэн Есүс Христэд би итгэдэг.
Би Ариун Сүнсэнд итгэдэг.
Ариун нэгдмэл чуулган,
Ариун хүмүүсийн нөхөрлөл,
Гэмийн уучлал,
Биений дахин амилалт болон
Мөнхийн амьдралд итгэдэг. Амен.

Бид энэхүү итгэлийн үндсэн тунхаглалууд бүхий *Элч нарын тунхгийг* гурван хэсэгт хуваан авч үзнэ. Нэгдүгээрт бид тунхгийн түүхийг, хоёрдугаарт тунхагт юу өгүүлдэг тухай товч тоймлон авч үзнэ. Гуравдугаарт, энэхүү тунхгийн онол сургаал нь өнөө цагт ямар ач холбогдолтой тухай ярилцах болно. Ингээд эхлээд *Элч нарын тунхгийн* түүхийг сөхөж үзэцгээе.

ТҮҮХ

Бид *Элч нарын тунхгийн* түүхийг судлахдаа хоёр зүйл дээр анхаарлаа хандуулах болно. Эхлээд бид тунхгийг хэн зохиосон, хэзээ бичигдсэн зэрэг түүхэн хөгжлийнх нь тухай ярилцана. Дараа нь чуулган яагаад тунхгийг зохиож, хэрэглэх нь чухал гэж үзсэн шалтгаан буюу зорилгыг авч үзнэ. Тэгэхээр эхлээд *Элч нарын тунхгийн* түүхэн хөгжлийн тухай ярилцъя.

ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Энэхүү *Элч нарын тунхгийг* анх нэгдүгээр зууны үед арван хоёр элч бичсэн гэж үздэг байлаа. Тэр ч бүү хэл үүнд буй теологийн арван хоёр өөр өөр тунхаглалуудыг элч бүр нэг нэгээр нь зохиосон гэх яриа ч бий. Ийм зүйл болсон эсэхийг, эсвэл элч нарын хэн нэг нь тунхгийг бичихэд шууд оролцсон гэдгийг нотлох баримт байхгүй. Тэгвэл үүнийг элч нар бичээгүй юм бол хэн бичсэн бэ?

Зохиогчийнх нь нэр байхгүй учраас *Элч нарын тунхгийг* хэн бичсэн бэ гэдэг асуулт өнөөг хүртэл хэвээр байна. Энэ асуулт бол Христээс хойш 40, 50 жилийн дараа ч баптисм хүртэгчдээс асуудаг асуулт байсан нь гарцаагүй. Тэднээс Тэнгэр газрыг бүтээсэн, Бурхан Эцэгт итгэж байна уу гэж асуудаг байсан байж таарна. Үүнийг бид олон олон хүмүүс баптисм хүртэхдээ эдгээр асуултуудад хариулсан байдгаас харж болдог шүү дээ. Мөн МЭ 200 оны үед Терталиус Хуучин Ромын Тунхгийн тухай дурдсан байдаг. Энэ нь *Элч нарын Тунхагтай* тун төстэй. Энд баптисмын асуултууд болох “Итгэж байна уу...?”, “Итгэж байна уу...?” гэсэн хэллэгүүдийг дурдсан байдаг. Элч нарын тунхгийн тухай хамгийн

анх МЭ 390 оны үед Руфинус гэдэг хүн дурдсан байдаг бөгөөд Иудасын оронд сонгогдсон Магтнаг оруулаад арван хоёр элчийн түүх бүрийг тунхгийн өгүүлбэр бүртэй холбон тайлбарласан байдаг. Үүнийг батлах түүхэн нотолгоо байхгүй ч тунхаг нь элч нартай холбогдох нь гарцаагүй тул ул үндэсгүй зүйл биш юм.

— Др. Жон Освалт

Анхны Христитгэгчдийн бичээсүүдэд *Элч нарын тунхагтай* төстэй олон чухал онол сургаалууд бий. Тэдгээр нь нэг талаараа итгэл үнэмшлийг нарийвчлан жагсааж, үндэс суурийг нь тайлбарладаг итгэлийн удирдамж заавар юм. Анхны сүмийн эцгүүдийн бичээснүүдэд тухайн сүм чуулганы итгэл үнэмшил болон дадал зуршлыг хураангуйлсан итгэлийн удирдамжууд байдаг. Жишээ нь, Ориген *Он Фөст Принциплес* номынхоо эхэнд итгэлийн дүрмийг оруулсан бол Ирениус нь *Гаж сургаалын эсрэг* хэмээх алдартай зохиолынхоо 1-р ботийн 10-р бүлэгт мөн тийм дүрэм оруулж өгсөн байдаг. Иймэрхүү итгэлийн удирдамжууд нь чуулганы сургаалыг хадгалан хамгаалах, мөн хүмүүсийг, ялангуяа ахлагч нарыг бэлтгэн сургах зорилготой байсан. Эдгээр нь ихэнхдээ чуулган бүрд харилцан адилгүй байв. Ерөнхийдөө үүнд чухал сургаал номлолын тунхаглал төдийгүй ёс суртахууны болон уламжлалт сургаалууд багтсан байдаг.

Нөгөөтгээгүүр эртний зарим онол сургаалууд нь тунхаг хэлбэрээр бичигддэг байсан. Өөрөөр хэлбэр чуулганы итгэлийн баримтлах удирдамж, тэр дундаа хамгийн чухал итгэл үнэмшлийг нэгтгэн хураангуйлсан жагсаалт гэж хэлж болно. Эдгээрийг голчлон баптисм зэрэг чуулганы ёслолын үеэр эш татан хэрэглэдэг байв. 1-2-р зууны үед чуулган бүр өөрийн гэсэн тунхаг, эсвэл библийн чухал үнэнүүдийг хураангуйлсан удирдамжтай болсон байлаа. Гэвч 3,4-р зуун гэхэд зарим нэг тунхгууд илүү ихээр түгэн дэлгэрч, олон сүм чуулганд адилхан ашиглагдах болсон юм.

Ийнхүү олны дунд түгсэн эртний тунхгуудын нэг бол Ромын чуулганаас гаралтай *Ромын тунхаг* юм. Энэ тунхаг *Элч нарын тунхагтай* тун төстэй. Тиймээс *Элч нарын тунхаг* бол *Ромын тунхгийн* дараагийн хувилбар гэж итгэдэг судлаачид ч олон бий. Гэвч чухам хаанаас гаралтайгаас үл хамааран *Элч нарын тунхаг* ялангуяа Барууны сүм чуулгануудад өргөн хэрэглэгдэх болсон нь эргэлзээгүй. Энэ тунхгийн үг хэллэг нь анхны зуунуудад чуулганаас чуулганд янз бүрээр өөрчлөгдсөөр ирсэн. Харин 8-р зууны үед үг хэллэгийг нь өнөөдрийн бидний ашиглаж байгаа стандарт загварт оруулсан байна.

Тунхгийн түүхэн хөгжийн талаар энэ ойлголтоо мартахгүй санаж байгаарай. Одоо бүгдээрээ *Элч нарын тунхгийг* бичих болсон зорилго болон үүнийг хэрхэн ашиглаж ирсэн талаар үзэцгээе.

ЗОРИЛГО

Өнөө цагт олон Хриситгэгчид аливаа тунхгуудад эргэлзэх болсон. Үүний шалтгааныг ойлгоход тийм ч хэцүү биш юм. Тунхгийг Бичвэртэй адил эрх мэдэлтэй гэж хэлэх хүн тун цөөхөн хэдий ч заримдаа Христитгэгчид сайн зорилгын улмаас л

аливаа тунхгийг Библи тэй адил тэнцүү гэж үзэх нь бий. Гэхдээ ямар ч тунхаг онолын хувьд ч, амьдрал дээр ч тийм өндөрт өргөгдөх ёсгүй.

Библи бол бидний итгэл болон амьдралын цорын ганц, алдаагүй мадаггүй удирдамж юм. Харин тунхаг бол Библийн ойлголтыг хураангуйлан заадаг, засаж сайжруулах боломжтой арга хэрэгсэл. Тэгвэл одоо бид *Элч нарын тунхаг* нь Христитгэгчдэд Библийн сургаалуудыг суралцаж, үнэнч үлдэхэд туслах зорилготойгоор бий болсон тухай үзэх болно.

Ингэхдээ *Элч нарын тунхгийн* зорилгыг гурван алхмаар судална. Нэгдүгээрт, бид Бичвэр бол жинхэнэ үнэн онол сургаалын эх сурвалж гэдгийг үзнэ. Хоёрдугаарт, сүм чуулганы уламжлалт сургаалууд нь Бичвэрийг л дагадаг тухай үзнэ. Гуравдугаарт, *Элч нарын тунхаг* нь чуулганы Бичвэрийн уламжлалт ойлголтыг хураангуйлах зорилготойгоор бичигдсэн гэдгийг үзэх болно. Ингээд үнэнч тууштай Христитгэгчид Бичвэр бол онол сургаалын үндэс гэдгийг үргэлж баталсаар ирсэн тухай эхлээд харцгаая.

Бичвэр

Анхын сүмийн эцэг болох Ориген 3-р зууны эхэнд бичсэн *Он Фөст Принциплес* гэдэг номынхоо удиртгалд юу гэж бичсэнийг хамтдаа сонсоцгооё:

Итгэдэг хүн бүр... хүнийг сайн сайхан, аз жаргалтай амьдрал руу хөтөлдөг мэдлэгийг өөр ямар ч эх сурвалжаас биш зөвхөн Христийн үг, сургаалаас олж авах ёстой. Христийн үг гэж хэлэхдээ бид зөвхөн Түүний хүн байхдаа хэлсэн үгийг биш... харин үүнээс ч өмнө Бурханы Үг болох Христ нь Мосе болон эш үзүүлэгчдийн номуудад байсан, ...түүгээр ч зогсохгүй... Түүний тэнгэр өөд одсоныхоо дараа ч элч нараараа дамжуулан хэлсэн бүхий л үгийг хэлж буй юм.

Энд Ориген Бичвэрийн бүхий л хэсгүүдэд Христийн үг байдаг бөгөөд энэ нь бүх үнэн онол сургаалын эх сурвалж гэж заажээ. Тэгвэл одоо 3-р зууны эхээр амьдарч байсан бишоп Хипполитус *Эгэйнст ди Хэрэйси оф уан Ноэтус* гэдэг номынхоо 9-р хэсэгт бичсэн үгийг сонсьё:

Ахан дүүс минь, цор ганц Бурханы тухай мэдлэгийг бид өөр ямар ч эх сурвалжаас биш, харин Ариун Бичвэрээс л олж мэддэг.

Анхны чуулганууд Библийг бүхэлдээ элч нараар дамжуулан итгэгчдэд өгөгдсөн Христийн үг гэж итгэдэг байв. Тиймээс тэд теологичдийн *Сола Скрипт* буюу *Зөвхөн Бичвэр* гэдэг ойлголтыг дагадаг байсан. Өөрөөр хэлбэл энэ нь Бичвэр бол итгэлийн цорын ганц алдаагүй мадаггүй удирдамж ба теологийн ямар ч маргааны эцсийн шүүгч мөн гэсэн ойлголт юм.

Бид үүний тод жишээг МЭ 370 онд Кайсари хотын бишопоор сонгогдсон Базилийн бичсэн зүйлсээс харж болно. Базил чуулганы уламжлал ба ёс заншлыг хүчтэй хамгаалагч нэгэн байсан. Тэрээр тэдгээр уламжлалууд нь угтаа элч нараас улбаатай гэдэг итгэл үнэмшлээ ч үргэлж илэрхийлдэг байв. Гэсэн хэдий ч эдгээр уламжлалууд нь үнэн зөв эсэх талаарх асуулт гарч ирэхэд тэрээр Бичвэрийг эцсийн эрх мэдэл гэж үзсэн. Эустатиус эмчид бичсэн *189-р захидалдаа* Базил юу гэж хэлснийг хамтдаа сонсоцгооё:

Бурханы онгодоор бичигдсэн Бичвэр бидний дунд шүүгч болтугай. Тэгээд аль талд нь Бурханы үгтэй нийцсэн онол сургаал байна тэр талыг үнэн гэж үзэн, санал өгөх нь зүйтэй.

Зарим чуулганууд итгэлийн удирдамждаа нэгэн хэлбэрийн уламжлалт үзлийг баримталдаг бол бусад чуулгануудын уламжлал үүнтэй зөрчилдөж байдгийг Базил энд хүлээн зөвшөөрсөн байна. Тиймээс тэрээр энэ асуудлыг шийдэхэд Библи хамгийн дээд эрх мэдэлтэй гэж үзжээ.

Анхны чуулганууд Бичвэр бол бүх онол сургаалын үндэс гэдэгт бат итгэлтэй байсан. Гэвч Бичвэрийн сургаалыг хураангуйлж, хамгаалахын тулд чуулганы *уламжлалт сургаалд* түшиглэсэн хэвээр л байв.

Уламжлалт сургаал

Тэгвэл чуулган яагаад уламжлалт сургаалаа сахин хадгалах шаардлагатай гэж үзсэн юм бол? Зөвхөн Библиэ л чандлан сахиад явахад хангалтгүй байсан гэж үү? Библи өөрөө бидэнд заагаад явчихна шүү дээ?

Тэгэхээр, сүм чуулган чухам юунд итгэдгээ товч бөгөөд тодорхой илэрхийлсэн мэдэгдэл гаргах шаардлагатай байсан. Ялангуяа элч нарын заасныг мушгиж, Библийн сургаалыг гуйвуулдаг хуурамч багш нар байсан. Тиймээс тэдгээр хуурамч сургаалуудаас хамгаалахын тулд чуулган юунд итгэдгээ тодорхойлсон хураангуй мэдэгдэл боловсруулах зайлшгүй шаардлагатай тулгарсан юм.

— Др. К. Эрик Тоенос

Чуулган Бичвэрийг итгэлийнхээ үндэс болгодог байсан хэдий ч Бичвэр маш урт бас үг хэллэг нь хязгаарлагдмал байсан нь мэдээж. Тиймээс Библийг бүхэлд нь уншихгүйгээр итгэлийн чухал зүйлсийг ойлгож ухаарахад нь хүмүүст туслахын тулд үндсэн онол сургаалаа нэг тунхагт багтаан хураангуйлах нь чуулганы хамгийн зөв гарц байсан.

— Др. Риад Кассис, орчуулга

МЭ 397 он хүртэл Бичвэрийн Канон албан ёсоор бүрдээгүй байсан учраас чуулганы эхэн үеийн түүхэнд *Элч нарын тунхаг* чухал ач холбогдолтой байв. Тэгэхээр чуулганы хамгийн эрх мэдэл бүхий итгэл юу байсан бэ? Үүнийг л *Элч нарын тунхагт* хураангуйлан оруулсан юм. Мэдээж тэр үед Библи байсан. Тэгсэн хэр нь яагаад тунхаг хэрэгтэй болсон юм бол? Учир нь хүмүүсийг Христитгэгч гэж хүлээн зөвшөөрөхийн тулд Библийг бүхэлд нь ойлгохыг шаардах боломжгүй байсан. Элч нарын тунхагт Библийн чухал сургаалуудыг хураангуйлж илүү хялбар болгосон гэсэн үг. Ийм л учраас тунхгийг өнөөдөр ч ашиглах хэрэгтэй.

— Др. Пол Чан, орчуулга

Хуурамч багш нар сүм чуулганд олон бэрхшээл авчирдаг. Тэдний зарим нь сайнмэдээний гол цөмийг үгүйсгэдэг. Ийм нөхцөлд Христитгэгчдийн итгэмжит удирдагч нар Бичвэрийн гол цөм сургаалыг хураангуйн боловсруулсан нь итгэгч бүр итгэлийнхээ үндсэн агуулгыг ойлгож, дагахын тулд юм. Ориген *Он Фөст Принциплес* гэдэг номынхоо удиртгалын өөр нэгэн хэсэгт юу гэж тайлбарласныг сонсоцгооё:

Христийн үзэл санааг дагадаг гэж боддог олон хүн бий. Гэвч тэдний зарим нь итгэлийн эцгүүдээсээ өөр бодолтой байдаг. Тэд элч нараас уламжлагдан, өнөөг хүртэл чуулганд хадгалагдан ирсэн, сүм чуулганы болон элч нарын уламжлалаас огтхон ч ялгаагүй үнэн гэж хүлээн зөвшөөрөгдөх ёстой *чуулганы сургаалаас* ч зөрсөн байдаг.

Энд Ориген юу гэж хэлснийг анзаарав уу. Тэрээр чуулганы сургаал бол алдаа мадаггүй эсвэл үргэлж зөв байдаг гэж хэлээгүй байна. Харин чуулганы сургаал элч нараас үе дамжин түүний амьдарч буй цаг үе хүртэл уламжлагдсан ирсэн *учраас л* үнэн гэж хүлээн зөвшөөрөгддөг байсан гэж хэлсэн байна. Өөрөөр хэлбэл Оригений амьдарч байсан цаг үед чуулганы сургаал нь Бичвэр дэх Христийн үгийн алдаагүй зөв хураангуй нь байсан ажээ. Тийм учраас л чуулганы сургаалыг тухайн үеийн онол сургаалуудыг шалгах “стандарт” ба “итгэлийн удирдамж” болгон ашиглах боломжтой байсан. Гэхдээ бүхий л дээд эрх мэдэл тухайн цаг үеийнхээ *сүм чуулганд биш* харин *Шинэ Гэрээнд* л байдаг.

Энэ санааг бид хэд хэдэн холбоос цагариг бүхий гинжтэй зүйрлэж болох юм. Анхны чуулган Христээс бат зуурахыг хүсэж байсныг бид Библиэс хардаг. Тиймээс *Христ* бол гинжний эхний цагариг юм. Элч нар Христтэй шууд харилцаатай байж, Түүнээс суралцаж байсан. Тиймээс *элч нарын сургаал* бол гинжний хоёр дахь цагариг. Элч нар хожим нь Бичвэр дэх Христийн талаарх мэдлэгээ сахин хадгалж, бичиж буулгаснаар *Бичвэр* нь гинжний гурав дахь цагариг болсон. Энэхүү эхний

гурван цагариг нь Ариун Сүнсээр хөтлөгдсөн тул төгс төгөлдөр бас алдаа мадаггүй байв.

Харин дөрөв дэх цагариг болсон *сүм чуулганы уламжлалт сургаал* номлол нь эдгээрээс ялгаатай. Энэ нь уламжлал болон дамжихдаа алдаа мадаггүй байсангүй. Ариун Сүнс тэднийг алдаанаас ангид байлгах баталгаа өгөөгүй юм. Үнэндээ зарим чуулганы уламжлал бусад чуулганыхтай зөрчилдөх тохиолдол олон байдгийг бид өмнө нь үзсэн билээ.

Тэдгээр зарим сургаалууд нь Библид шууд тодорхой заагаагүй жижиг асуудлууд байдаг. Харин бусад уламжлалууд нь *Элч нарын тунхагт* заасан шиг нэн ялангуяа итгэлийн үндсэн тунхаглалуудын талаарх Библийн анхны утга санааг хураангуйлсан байдаг.

Үндсэн цөм итгэл үнэмшилтэй холбоотой уламжлалуудыг үе үеийн турш газар бүрд сүм чуулгануудын ахлагч, удирдагч нар итгэн дагасаар ирсэн. Түүнчлэн эдгээр уламжлалуудыг Библиэс шууд шалган баталгаажуулж болдог. Ориген *чуулганы уламжлалт сургаалыг* итгэлийн удирдамж гэж бичихдээ тун итгэлтэй байсны учир нь энэ юм.

Гэвч энэ цагариг алдаа мадаггүй төгс байгаагүй. Сүм чуулганууд, түүний зөвлөлүүд болон итгэгчдийн хувьд үргэлж алдаа гаргах боломжтой байсан. 3-р зууны Картэйжийн Бишоп Сиприаны Ромын Бишоп Стефений онол сургаалыг эсэргүүцэн бичсэн 73-р захидалдаа юу гэснийг хамтдаа сонсоцгооё:

Зарим хүмүүсийн дунд шургалсан ямар ч уламжлал нь үнэнийг ялахыг зогсоож чадахгүй. Үнэн үгүй уламжлал бол эрт цагийн алдаа юм.

Энд Сиприан хэлэхдээ Христитгэлийн зарим нэг эртний үзэл суртал болон зан үйл нь элч нараас бидэнд дамжин ирсэн үнэнд суурилагагүй гэжээ. Харин тэдгээр нь олон жилийн өмнөөс л чуулганд чимээгүй орж ирсэн “эрт цагийн алдаа” гэсэн байна. Үнэндээ хүмүүний энэхүү алдаатай байдлын улмаас л чуулган итгэлийн удирдамжийг бичгийн хэлбэрээр үлдээх нь чухал болсон юм. Ориген болон бусад чуулганы эцгүүд *итгэлийн удирдамжийг* бичиж үлдээсэн зорилго бол дэлхий даяарх Христитгэгчид өөрсдийн онол сургаалаа уламжлалт сургаалтай харьцуулан үзэх боломжийг олгох явдал байв. Чуулганы зөвлөлүүд ч мөн уламжлалт онол сургаалаа бичиж үлдээснээр үе үеийн, газар бүрийн Христитгэгчид хэзээд ашиглаж болох шүүлтүүртэй болсон юм.

Ямар ч тохиолдолд чуулганы уламжлалт сургаалыг сахин хадгалсаар ирсэн чин зорилго нь чуулганууд Библийн анхны утга санаанаас хазайхгүй байж, итгэгчид элч нарын сургаалыг зөвөөр ойлгон, Христийн үгийг баттай ухаарч, түүгээр амьдрах явдал байсан юм.

Нэг талаараа Библи бол маш том ном учраас та бүгдийг нэг дор ярьж тайлбарлаж чадахгүй шүү дээ. Тиймээс та үүнийг сайтар хураангуйлах шаардлагатай болно. Шинэ Гэрээнд хүртэл Христ гэж хэн болох тухай онол сургаалыг тодорхойлоход бэрхшээлтэй

байдаг. Шинэ Гэрээнд элч нар “Үгүй ээ, үнэн бол энэ юм” гэдгийг ойлгуулах гэж их хичээсэн байдгийг бид мэднэ. Есүс гэж хэн болох, мөн Библийн үндсэн ойлголтууд юу байдаг тухай томоохон асуудлууд хоёрдугаар зуунд ч үргэлжилсээр байсан юм. Тиймээс тэд библийн ойлголтуудыг аль болох товч, богино болгон хураангуйлах ёстой болсон. Энэ нь л *Элч нарын тунхгийг* бий болгосон хэрэг л дээ. Гэхдээ хамгийн чухал нь бид энэ бол Библи дээр ямар нэг зүйл нэмэх гэж биш харин утга санааг нь ойлгуулах зорилготой гэдгийг санах хэрэгтэй.

— Др. Петр Волкер

МЭ 374 онд Базил *Он Ди Холи Спирит* номдоо ингэж бичсэн байна:

Бид эцгүүдийн хэлсний адилаар явдаг... Гэхдээ бид зөвхөн тэднээс дамжин ирсэн уламжлалыг л дагадаггүй. Учир нь эцгүүд ч бас Бичвэрийг дагадаг байсан юм.

Анхны чуулган уламжлалт сургаалаа хамгаалахдаа онол сургаалын жижиг асуудлуудын талаар төдийлөн санаа зовдоггүй байсныг энд хэлэх нь зүйтэй. Тэд итгэлийн үндсэн суурь, чухал зүйлс болон хэрэгжүүлэлт дээр гол анхаарлаа хандуулдаг байсан. Энэ нь ч тэдний бичсэн зүйлсдээ хөндсөн асуудлууд болон итгэлийн удирдамждаа багтаасан зүйлсээс харахад тун тодорхой байдаг.

Жишээ нь, тэд Христийн *хүн мөн чанарыг* үгүйсгэдэг Докетистуудын эсрэг бичиж байсан. Тэд мөн Хуучин Гэрээний Бурхан бол махан биеийн бүхий л гэм нүглийг зөвшөөрдөг, ёр муу Бурхан байсан гэж итгэдэг Гностик үзэлтнүүдийн эсрэг ч бичиж байв. Тэд Библийн үндсэн итгэлийг үгүйсгэдэг бусад олон хуурамч сургаалуудын эсрэг бичсэн.

Бид Бичвэр болон чуулганы уламжлалт сургаал номлолын тухай ярилцлаа. Одоо бүгдээрээ *Элч нарын тунхаг*т чуулганы уламжлалт сургаалыг итгэгч бүрд зориулан хэрхэн хураангуйлсан болохыг үзэхэд бэлэн боллоо.

Элч нарын тунхаг

Шинэ Христитгэгчид Библийн үндсэн сургаалд итгэж буйг *Элч нарын тунхгаар* баталгаажуулдаг байсан тухай бид үзсэн. Орчин үеийн чуулганууд шинэ итгэгчдээ Библи судлал болон сургалтуудаар дамжуулан дагалдуулдагтай адил анхны чуулган шинэ итгэгчдээ тунхгаар дамжуулан итгэлийн үндсэн ойлголтуудыг зааж сургадаг байжээ.

МЭ 354-с 430 оны хооронд амьдарч байсан Хиппогийн алдарт Бишоп Августин нь Катекюмен буюу баптисм хүртэх гэж буй шинэ итгэгч нарт зориулан номлохдоо тунхгийн үнэ цэнийг хураангуйлсан байдаг. Тэрхүү номлолыг бэлтгэхдээ түүний гол баримталсан тунхаг бол Никаиагийн тунхаг байсан ч түүний үг бүр чуулганы эхний хэдэн зууны бүхий л тунхгуудын зорилго ба хэрэглээг хураангуйлан

хүргэж чадсан юм. *Тунхгийн тухай Катекюмен нарт зориулсан номлолдоо* Августин ийнхүү бичжээ:

Та бүхний Тэнгэрлэг Бичвэрээс сонссон үгс тань Бичвэрийн энд тэнд янз бүрийн хэсэгт бий. Тиймээс эдгээрийг нэгтгэн, хураангуйлж удаан нэгэн ч ойлгож тогтооход хялбар болгов. Ингэснээр хүн бүр итгэдэг зүйлсээ хэлж ярьж, хоргодон найдах боломжтой болох юм.

Августин энд Христитгэлийн үндсэн цөм сургаалууд нь Библийн энд тэнд, тарсан байдаг гэдгийг онцлон хэлжээ. Тиймээс эртний чуулганууд Библийн үндсэн гол сургаал номлолыг тунхаг бичигт хураангуйлан буулгасан гэжээ. Ингэснээр итгэгч бүр буюу түүний хэлснээр “удаан” нэгэн нь эсвэл боловсролгүй нэгэн нь ч Бичвэрийн үндсэн сургаалуудыг амархан ойлгож чадна.

Мэдээж сүм чуулганууд өөр өөр тунхагтай байсан нь итгэлийн шалгуурууд нь ч өөр өөр байсан гэсэн үг юм. Зарим чуулган шинэ итгэгч нараас бүгдийг ойлгохыг шаарддаггүй байхад зарим нь тэднийг чин итгэлтэй боловч теологийн мэдлэггүй л бол итгэгч гэж тооцдоггүй байжээ. Үүнээс болж хэн нэгэн нь зарим чуулганд итгэгч гэж хүлээн зөвшөөрөгдөх хэр нь заримд нь хүлээн зөвшөөрөгддөггүй байв. Энэ эрс ялгаатай байдлаас болж анхны чуулганууд Христитгэлийн гэдэг цуглаан бүр хүлээн зөвшөөрөхүйц тунхаг гаргах нь зайлшгүй шаардлагатай гэдгийг ойлгосон.

Яг энэ л хэрэгцээ шаардлагыг хангахын тулд *Элч нарын тунхаг* нь олонд танигдаж түгсэн. Энэ бол Христитгэгч хүн бүр ойлгох боломжтой бас ойлгох ёстой итгэл үнэмшлийн товч тодорхой тунхаглал байж чадсан.

Элч нарын тунхаг бол үнэндээ Христитгэлийн тухай хураангуй хүүрнэл юм. Бид Библийн үг бүр нь Бурханы алдаа мадаггүй, хувирч өөрчлөгдөшгүй үг гэдэгт итгэдэг. Гэсэн хэдий ч бид хүмүүст сайнмэдээний мөн чанарыг ойлгоход нь туслахын тулд хураангуйлах шаардлагатай болдог. *Элч нарын тунхаг* бол Христитгэлийн түүхэн замналын эхэнд гарч ирсэн, итгэлийн мөн чанарын талаарх Христийн илчлэл дээр үндэслэн элч нарын заасан бүхнийг нэгтгэсэн хураангуй юм. Бүх зүйл “Би итгэдэг” гэх энэ үгнээс л урган гардаг. Тиймээс хамгийн чухал зүйл бол *Элч нарын тунхаг* нь сайнмэдээг хангалттай ойлгуулахын тулд ярих ёстой бүхнийг хэлж, тайлбарлахад бидэнд тусалдаг юм.

— Др. Р. Алберт Мохлер, Жр.

Ингээд бид *Элч нарын тунхгийн* түүхийн тухай ярилцсан тул одоо тунхагт юу өгүүлснийг тоймлон үзэхэд бид бэлэн болжээ. Христитгэгчид чухам юунд итгэдгийг бүхэлд нь харуулж чадсан энэ тунхаг чуулганы эхэн үед хэрэгтэй байсны адил өнөөдөр ч хэрэгтэй хэвээр байгаа билээ.

ТОЙМ

Олон жилийн турш *Элч нарын тунхгийн* агуулгыг теологичид янз бүрээр тайлбарласаар ирсэн. Энэ хичээлээр бид тунхагт өгүүлсэн итгэлийн үндсэн тунхаглалуудыг гурван өөр талаас нь авч үзэх болно. Эхлээд бид *Бурханы* тухай онол сургаалыг үзэх болно. Хоёрдугаарт, *чуулганы* тухай. Гуравдугаарт, бид *авралын* тухай ярих болно. Ингээд элч нарын тунхаг дахь Бурханы тухай онол сургаалыг эхлээд үзэцгээе.

БУРХАН

Бурханы тухай онол сургаал нь Христитгэлийн теологи, Христитгэлийн итгэл үнэмшил, Христитгэлийн амьдралд туйлын чухал юм... Хүн өөрийгөө болон дэлхий ертөнцийг мөн амьдралын зорилго ба утга учрыг таньж мэдэх гээд бүхий л зүйлс эцэстээ бүгд л Бурхан гэж хэн бэ гэдэгтэй холбогддог... Авралын тухай, чуулганы тухай, эцсийн өдрүүдийн тухай гээд Христитгэлийн онол сургаал бүр амьд буй, гурвалаар оршигч Бурханд л үндэслэдэг. Бидний амьдралын бүхий л итгэл, найдвар, аврал ба нүглийн уучлал гээд бүгд л эдгээрийг анхнаас нь *эхлүүлж*, хүсэл зорилгынхоо дагуу *удирдаж*, төлөвлөгөөгөө гүйцэлдүүлэхийн тулд энэ бүхнийг *дуусгах* тэр л Бурханаас эх үндэстэй байдаг. Тиймээс бүх зүйл эргээд бид Бурханыг хэн гэж боддогтой холбогддог юм.

— Др. Стефен Ж. Вэллум

Элч нарын тунхагт Бурханы тухай онолын хоёр гол онол сургаалыг тусгасан байдаг. Нэгдүгээрт, энэ нь Бурхан бол Гурвалаар оршигч гэдэг итгэл үнэмшил дээр суурилдаг. Хоёрдугаарт, энд Бурханы гурван бодгаль болох Эцэг, Хүү, Ариун Сүнсний талаарх тунхаглалыг багтаасан байдаг. Ингээд эхлээд Гурвалын тухай авч үзье.

Гурвал

Элч нарын тунхаг нь гурван гол хэсэгт хуваагдаж, хэсэг бүр нь “Би итгэдэг” гэдэг үгээр эхэлж байгааг та бүхэн анзаарах нь лавтай. Эхний хэсэг нь Бурхан Эцэгт итгэх итгэлийн тухай байдаг. Хоёр дахь хэсэг нь Бурханы цорын ганц Хүү, Бидний Их Эзэн Есүс Христийн тухай байдаг. Гурав дахь хэсэг нь Ариун Сүнсний талаарх итгэлийг багцлан, идэвхтэй үйлчлэлийнх нь тухай жагсаан бичсэн байдаг.

Есүс Христтэй холбоотой зүйлсийн тухай ярихаас өмнө тунхгийн эртний хувилбарууд бүгд “Би итгэдэг” гэдэг үгийг ашигласан байгаагүй гэдгийг хэлэх нь

зүйтэй. Ихэнх нь “ба эсвэл болон” гэдэг үгийг ашигласан байсан ба энэ нь “би итгэдэг” гэдэг үгтэй адил хүчтэй утгыг илэрхийлсэн байдаг. Тунхгийг Бурханы бодгалиудад хуваасан нь ямартай ч бүхий л тохиолдолд чуулганаар хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Үүнийг Гурвалын онолыг баримтлах гэж нэрлэдэг. Энэ бол Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн гурвалаар оршигч нэг Бурхан байдаг гэдэг итгэлийг баримталдаг гэсэн үг.

Энэхүү нэршлийг бид Матай 28:19 дээрээс харж болно. Есүс дагалдагч нартаа дараах тушаалыг өгсөн байдаг. Энд:

“Иймээс та нар яв, бүх үндэстнийг дагалдуул. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээ...” гэжээ (Матай 28:19).

Элч нарын тунхагт байгаатай яг адилхан энд Эцэг, Хүү, Ариун Сүнс гэдэг гурван нэр гурвуулаа ижил тэнцүү байдлаар тус тусдаа орсон хэдий ч нэг Бурхан байгааг илтгэж байна.

Элч нарын тунхагт “Гурвал” гэдэг үгийг огт дурдаагүй, мөн нарийвчлан тайлбарлаагүй байгааг анхаарна уу. Харин тунхаг бол итгэлийн чухал зүйлсийн хураангуй болохоос биш дэлгэрэнгүй тайлбар биш гэдгийг бүү мартаарай. Тунхгийг чуулганы ёслолд ашиглахдаа Бурханы эдгээр бодгалиудыг дурдсан байгаа нь хүн бүр энэ нь Гурвалын тухай ойлголтыг илэрхийлж байгааг мэддэг байсныг харуулдаг.

Гэхдээ Христитгэгч бүр Гурвал гэдэг үгний утга учрыг бүрэн мэддэггүй учраас бид үүнийг эхлээд тайлбарлах хэрэгтэй. Гурвалыг ихэнхдээ дараах байдлаар тайлбарладаг:

Бурхан бол гурван бодгальтай ч мөн чанарын хувьд нэг юм.

Бодгаль гэдэг нэр томъёо нь ангид, ухамсартай хувь чанарыг хэлдэг. Харин *мөн чанар* гэдэг нь Бурханы үндсэн мөн чанар эсвэл түүний оршин байдаг чанарыг хэлж байгаа билээ.

Мэдээж хүний хувьд Гурвалын тухай ойлголтыг бүрэн дүүрэн ойлгох нь маш хэцүү. Бурханы мөн чанар болон оршин байх хэлбэр нь бидний мэдрэхүйгээс хэтийдсэн байдаг тул түүний тухай ойлгож ухаарах нь амаргүй. Хэдий тийм ч Гурвал бол Христитгэлийн чухал онцгой итгэл үнэмшил юм. Гэвч ийм ойлгоход хэцүү онол сургаал хэрхэн Христитгэлийн теологийн чухал тулгуур ойлголт болсон юм бол оо?

Тэгэхээр, та бид Гурвалыг ойлгохын тулд Библийг цогцоор нь судлах шаардлагатай болдог. Та ийнхүү унших үедээ тус тусдаа бодгалиар оршигч Эцэг Өөрөө Бурхан, Хүү ч Өөрөө Бурхан, Ариун Сүнс ч Өөрөө Бурхан мөн гэдгийг маш тодорхой ойлгох болно. Тиймээс Бичвэрийн сургаал номлолыг Гурвалын тухай гэх мэт онол сургаалтай нэгтгэн нийлүүлэх шаардлагатай байдаг юм.

— Др. К. Эрик Тоеннес

Тэгэхээр Гурвалын онол сургаал нь Христитгэлийн теологийн тулгуур ойлголт юм. Би үүнийг ихэд чухалчлан үздэг. Учир нь энэ бол библийн онол сургаал шүү дээ. Гэхдээ “г-у-р-в-а-л” гэдэг үг нь Бичвэрт байхгүй, харин энэ талаарх *ойлголт* л байдаг учраас бид үүнийг хэрхэн зөв ойлгох вэ гэдэгтээ анхааралтай байх хэрэгтэй. Бурхан гэж хэн бэ гэдэг Библийн бүх сургаалыг нэгтгээд үзвэл Бурхан бол ганц бөгөөд Эцэг бол Бурхан, Хүү бол Бурхан, Ариун Сүнс бол Бурхан гэж хэлсэн байдаг. Энэ бүгдээс харвал Бурхан бол гурвалаар оршигч Бурхан гэдэг дүгнэлтийг Библи бүхэлдээ гаргаж, бас баталгаажуулсан байдаг.

— Др. Роберт Ж. Листер

Тиймээс Бурхан бол угтаа нэг юм гэж хэлбэл бид нэг Бурхан байдаг гэсэн Библийн үнэнийг хамгаалж байгаа хэрэг. Харин гурван тусдаа бодгаль яаж нэг Бурхан байж болох вэ гэдгийг л бид тайлбарлах гэж оролдож байна шүү дээ. Бид *мөн чанар* гэдэг үгийг гурван бодгаль бүрийн бусадтайгаа хуваалцдаг зүйлийг хэлдэг. Өөрөөр хэлбэл хэрэв ямар нэг *зүйл* эсвэл *хэн нэгэн* Эцэгийнх гэвэл тэр нь мөн Хүүгийнх төдийгүй Ариун Сүнснийх гэсэн утгатай байна.

Бид Бурхан бол гурван бодгалиар оршдог гэж хэлбэл Эцэг, Хүү, Ариун Сүнс бие биеэсээ тусдаа байдаг гэсэн Библийн үнэнийг мөн л хамгаалж байгаа хэрэг. Тэд бол бие биетэйгээ ярилцдаг, харилцдаг, хамааралтай байдаг, тус тусдаа бодгалиуд юм. Гурвалын тухай ойлголт бол олон талаараа агуу нууц ч гэсэн мөн бидний гайхамшигтай Бурханы мөн чанарын талаарх Библийн олон сургаалыг оновчтой нэгтгэн буулгасан онол юм.

Гурвалын тухай ойлголт нь Христитгэлийн теологийн хувьд олон талаар маш чухал юм. Жишээ нь, энэ онол Есүс бол Бурхан бөгөөд харагдах байдлаараа Эцэг шигээ биш гэсэн библийн үнэнийг хамгаалдаг. Мөн энэ онол бид яагаад Эцэг, Хүү, Ариун Сүнс гуравт тус бүрд нь залбирдаг хэдий ч монотеизмд буюу цорын ганц Бурханд итгэж хүндэлдгийг тайлбарлаж өгдөг. Үүнээс ч илүүгээр, энэ нь бидэнд Бурханы бодгаль бүрийг зохих ёсоор хүндлэхэд маань тусалдаг. Мөн Бурханы аль нэг бодгалийнх нь оршихуй ба тусламж нь үнэндээ Бурханы Өөрийнх нь оршихуй ба тусламж юм гэсэн ойлголт биднийг тайвшруулдаг. Үнэн хэрэгтээ Гурвалд итгэх итгэл бол Христитгэлийн өөр олон олон ойлголтын үндэс суурь бөгөөд Христитгэлийн түүхэн замналыг энэ итгэлгүйгээр төсөөлөхийн аргагүй юм.

Ингээд бид *Элч нарын тунхаг* дахь Бурханы тухай онолыг ярилцаж дууслаа. Харин одоо энэхүү тунхаг дахь Бурханы бодгалиудын талаарх тунхаглалыг тус бүрд нь хэрхэн тодорхойлсныг үзэхэд бэлэн болж байна.

Бурханы бодгалиуд

Бурхан Эцэгийн тухайд, тунхагт Түүний төгс хүчит чанарыг тодотгон, тэнгэр газрыг Бүтээгч гэдэг түүхэн үнэнийг дурдсан байдаг.

Гэхдээ мэдээж Бурханд хязгааргүй хүч чадал, бүрэн эрхт байдлаас хавь илүү гайхамшигтай чанар бий. Тэрээр хорвоо ертөнцийг бүтээснээсээ илүү гайхамшигтай үйлсийг бүтээсэн. Зарим талаараа тунхагт Эцэгийн тухай тайлбарласан нь тэнгэрлэг эрх мэдэлтэй бүтээгчид итгэдэг бусад шашнаас төдийлөн ялгаагүй мэт харагддаг. Гэсэн ч Эцэгийн талаарх анхны чуулганы энэхүү тодорхойлолт нь Христитгэлтэй нийцэж байгааг харуулахад хангалттай гэж үзсэн байдаг. Мөн тэд тунхгийн бусад тайлбарууд Христитгэлийг өөр шашнуудаас ялгахад тусална гэдэгт итгэлтэй байсан.

Тухайлбал тунхагт Хүү буюу Есүс Христийн тухай илүү олон зүйлийг дурдсан байдаг. Хэдийгээр Есүсийн мөн чанарыг огт дүрслээгүй ч, итгэгч биш хүмүүсийн үгүйсгэдэг Түүний газар дэлхий дээрх амьдрал ба үйлчлэлийн тухай нэлээд хэдэн зүйлийг дурдсан байдаг.

Тунхагт Есүсийн хүн болсон тухай, хүний хүүхэд болж мэндэлсэн тухай, жинхэнэ хүний амьдралаар амьдарсан тухай дурдсан. Мөн Түүний эдэлсэн зовлон, үхэл, оршуулга, үхлээс амилсан болон тэнгэр өөд одсон тухай бүгдийг багтаасан байдаг. Энэ бүх үндсэн гол үйл явдлуудыг итгэгч бус хүмүүс үргэлж үгүйсгэж байсныг Библиэс бид харж болно.

Өнөөдөр ч хүртэл олон либерал түүхчид, теологичид олон гаж буруу урсгал болон хуурамч шашнуудын адилаар эдгээр үнэнийг үгүйсгэсээр байгаа. Жишээ нь, Исламчууд Есүсийг Бурханы эш үзүүлэгч гэж итгэдэг. Гэвч Түүнийг хэзээ ч загалмайд цовдлогдож, үхлээс амилаагүй гэдэг ба Түүний бурханлаг чанарыг үгүйсгэдэг юм.

Эцэст нь, тунхаг Есүс бол эцсийн өдрүүдэд бүх хүнийг шүүж, хорон мууг шийтгэж, итгэгчдэд мөнхийн амь ба ерөөлийг өгөх Нэгэн мөн гэдгийг тунхагласан байдаг.

Харин тунхагт Ариун Сүнсний тухай өгүүлэхдээ Онгон Мариа нь Ариун Сүнсээр хэвлийдээ үртэй болсон тухай байдаг. Нөгөө талаасаа тунхагт Түүнийг тусдаа Бурханы нэгэн бодгаль гэдгийг шууд тунхагласан. Мөн Ариун Сүнсийг чуулган болон одоо ба ирээдүйн авралтай шууд бусаар холбосон байдаг.

Бид Бурханы эдгээр бодгаль бүрийн тухай илүү дэлгэрэнгүйг дараагийн хичээлүүдээр үзэх болно. Энэ хичээлээр бид тунхаг нь зөвхөн Гурвалын онолын тухай заагаагүй, харин Гурвалын бодгаль бүр Христитгэлийн цөм ойлголт гэдгийг онцлон харууллаа. Хэдийгээр энд дэлгэрэнгүй нарийвчлан тайлбарлаагүй ч Тунхаг нь Христитгэлийн түүхэн итгэл үнэмшлийг хүлээн авдаг итгэгчдийг хүлээн авдаггүй хүмүүсээс хангалттай ялгах хэмжээнд Бурхан ба Түүний хүмүүсийн тухай өгүүлсэн байдаг.

Ингээд Бурханы тухай ямар онолыг тунхагласныг бид үзсэн учраас одоо *Элч нарын тунхагт* чуулганы тухай юу гэж хэлснийг үзэхэд бэлэн боллоо.

ЧУУЛГАН

*Элч нарын тунхаг*т чуулганыг хоёр янзаар тайлбарласан байдаг. Нэгдүгээрт, чуулганыг ариун нэгдмэл чуулган гэсэн. Хоёрдугаарт, ариун хүмүүсийн нөхөрлөл гэж хэлсэн байдаг. Энэ хоёр өгүүлбэрийг олон янзаар хэрхэн орчуулсныг бид дараа дараагийн хичээлээр илүү дэлгэрэнгүй үзнэ. Харин одоо ариун нэгдмэл чуулган гэдэг нь Ромын католик чуулганыг хэлээгүй гэдгийг энд онцлон хэлмээр байна. Харин энэ бол дэлхийн өнцөг булан бүрд байгаа даяар чуулганыг хэлж байгаа юм.

Гэсэн хэдий ч протестант хүмүүст ямар ч төрлийн бүх чуулганд итгэнэ гэхээр хачирхалтай санагдаж байж болох юм. Тиймээс “Би...чуулганд...итгэдэг” гэсэн тунхгийн хэллэг нь бид сүм чуулганд итгэлээ өгнө гэсэн утгатай биш гэдгийг тайлбарлах хэрэгтэй байх. Харин энэ нь чуулган бол ариун буюу “ариусгагдсан” мөн “нэгдмэл” буюу даяар юм гэдэгт итгэж байгаагаа тунхагласан гэсэн утгатай байна.

Мөн энд *ариун хүмүүсийн нөхөрлөлд* итгэж байгаагаа илэрхийлсэн нь итгэгч нарын нөхөрлөлийг хэлж байгаа хэрэг. Эндээс харахад Христитгэлийн түүх нь чуулганы ач холбогдлыг онцолсоор ирснийг харуулдаг.

Энэ хичээлээр бид *Элч нарын тунхаг* дахь итгэлийн үндсэн тунхаглалуудын чуулгантай холбоотой хоёр чухал талыг анхааран үзэх болно. Нэг талаас бид чуулганд оролцох тухай авч үзнэ. Нөгөө талаас чуулган онол сургаалыг хэрхэн хадгалан үлддэг талаар авч үзнэ. За эхлээд чуулганд харьяалагдах тухай авч үзье.

Оролцоо

Тунхагт “Би ариун...чуулганд итгэдэг” гэж хэлсэн нь чуулганд оролцох нь чухал ач холбогдолтойг онцолж байна гэсэн үг. Учир нь Христитгэлийн чуулганы түүхэнд олон хүмүүс Бурханыг Эцэгээ болгож, Есүсийг Их Эзэнээ болгож, Ариун Сүнснийг Зуучаа болгохыг хүсдэг ч харагдах чуулган болох Бурханы хүмүүсийн нэгдлийн нэгэн хэсэг байхыг хүсдэггүй байв. Энэ тухай Еврей 10:25-р эшлэлээс хамтдаа харцгаая. Энд:

“Хамтран цуглахыг больж, зуршил болгосон зарим хүмүүсийг дагалгүй” гэжээ ... (Еврей 10:25).

Анхны зуунд хүртэл зарим итгэгчид чуулганд очиж магтан хүндэлж, сургаал сонсон, хамтдаа нөхөрлөхөөс зайлсхийдэг байжээ. Гэвч Библид чуулган бол Христитгэгчдийн хувьд чухал, зайлшгүй байх ёстой газар гэсэн байдаг.

Мэдээж, *Элч нарын тунхгийг* анх ашиглаж байсан хүмүүс ийм байгаагүй. Харин ч эсрэгээрээ тунхгийг чуулганы үйл ажиллагаанд ашиглаж, баптисм хүртэхээр чуулганыг зорин ирсэн хүмүүс үүнийг хүлээн авч, итгэн дагаж байсан юм. Тэд чуулгантай нэгдэн, цугларалтад хамрагддаг байв. Яг энэ загварыг дагахыг тунхаг бидэнд зааж өгдөг.

Өнөө цагт ч сүм чуулганд очихоос зайлсхийдэг Христитгэгчид олон байдаг. Ямар нэгэн зохион байгуулалттай шашинд дургүйгээс болдог байж болох юм. Эсвэл бусад Христитгэгчдэд гомдсон гомдлоосоо болсон ч байж болно. Эсвэл тэд Христитгэлийн ном уншиж, Христитгэлийн нэвтрүүлэг үзэж, цахим хуудсаар зочлох нь хангалттай гэж боддог ч байж болно л доо.

Гэвч Библид Христитгэгчдийг хамтдаа биеэр цуглан нэгдэхийг заадаг. Энэ нэгдэл нь итгэгч бүрд маш чухал гэдгийг онцолдог. Христитгэгчид хэдий Христ болон Ариун Сүнсээр дамжуулан сүнслэг байдлаар аль хэдийн нэгдэн нөхөрлөсөн байдаг ч зөвхөн сүнслэг нэгдлээр хязгаарлагдаж болохгүй. Бидний нэгдэл бол яг л гэр бүл эсвэл айл хөршүүд шиг байх учиртай. Бид бие биетэйгээ уулзаж ярилцаж байж энэ нэгдэл бүрэн дүүрэн болно.

Тэгэхээр чуулганд оролцохын ач холбогдлын тухай ойлгосон бол одоо чуулган доторх онол сургаалыг хэрхэн хадгалан хамгаалдаг тухай үзье.

Хамгаалалт

Тунхгууд бий болсон цагаас хойш үүнийг тогтмол унших, тунхаглах, цээжлэх, тэр дундаа чуулганд тунхаглан хэлэх нь нэгдүгээр зуунд, цаашлаад бичиг үсэг сайн тайлагдаагүй байсан Христитгэлийн эхэн үеийн нийгэмд маш чухал ач холбогдолтой байсан. Уншиж чаддаг хүн цөөн, уншиж чаддаг ч өөрийн гэсэн библиетэй хүн бараг байхгүй байсан. Тиймээс тунхгийг магтаал мөргөлийн үеэр хамтдаа тунхаглан унших нь хүмүүст итгэлийн шалгууруудыг буюу бидний хэлдгээр итгэлийн удирдамжуудыг ойлгуулж, Библийг хэрхэн яаж ойлгож, зохистой уншихыг зааж өгдөг байснаараа маш чухал үүрэг гүйцэтгэдэг байсан.

— Др. Ионатан Т. Пеннингтон

Итгэлийн удирдамжийн тухай дурдсанчлан чуулган ч мөн алдаа дутагдалгүй биш юм. *Элч нарын тунхаг* нь бидэнд чуулганыгаа заасан бүхэнд итгэж болно гэж заадаггүй. Харин Христ чуулганыг сайнмэдээ болон үнэнийг тунхаглаж, хамгаалах үйлсэд томилсон гэдгийг зааж өгсөн байдаг. Чуулганы зорилгын тухай захидлынхаа 3-4-р эшлэлд Есүсийн дүү Иуда юу гэж хэлснийг сонсоцгооё:

“Хайртууд аа, та нарт бидний хуваалцдаг авралын тухай бичихээр хичээн зүтгэж байхдаа ариун хүмүүст тушаагдсан итгэлийн төлөө тэмцэхийг та нарт ятган бичих шаардлагатай хэмээн би бодлоо. Учир нь... хэсэг хүн сэм шургалан орж ирсэн бөгөөд тэд Бурханы маань нигүүлслийг садарлал болгон гажуудуулж, бидний цорын ганц Эзэгнэгч бөгөөд Эзэн Есүс Христийг үгүйсгэж байна” гэжээ. (Иуда 3-4).

Иудагийн хэлснээр чуулганы үүрэг хариуцлагын нэг хэсэг бол хариуцаж буй үнэнээ хуурамч сургаал зааж, заншил болгосон хүмүүсээс хамгаалан, итгэлийнхээ төлөө тэмцэх явдал юм.

Өнөөдөр ч ялгаагүй олон сүм чуулганд хуурамч сургаал заадаг хүмүүс байсаар байгааг та нарын ихэнх нь анзаарсан байх. Бас гэм нүгэлтэй, ёс бус зүйлс ч ихээхэн үйлдэгдсээр байна. Тэгсэн ч Бурхан чуулганд өгсөн үүрэг даалгавраа хэзээ

ч цуцлаагүй бөгөөд үнэн сургаалыг хамгаалах энэ үүргийг өөр хэн нэгэнд эсвэл байгууллагад өгөөгүй. Үнэнийг хамгаалах нь одоо ч чуулганы үүрэг хэвээр байна.

Өнөөдөр ч чуулган энэ үүргээ биелүүлэхийн төлөө чармайн зүтгэсээр байна. Заримдаа бид үүнийг бусдаас илүү сайн биелүүлдэг. Бидний теологийн зарим сургаал Библид итгэмжтэй байж чадсан ч, сайжруулах хэрэгтэй зүйл зөндөө байдаг. Заримыг нь бүр өөрчлөх ч хэрэгтэй байдаг. Цаашид ч үргэлж ийм байх болно. Гэхдээ энэ хичээлээр бид чуулганы онол сургаалыг хамгаалахын төлөө үргэлж хичээж, бууж өгч болохгүй гэдгийг онцлон ойлгуулахыг хүссэн юм. Бид энэ дуудлагаа орхих юм бол “*Би чуулганд итгэдэг*” гэсэн Христитгэлийн түүхэн итгэл үнэмшлийн чухал ойлголтыг үгүйсгэж буй хэрэг болно.

Ингээд бид Бурхан болон чуулгантай холбоотой итгэлийн үндсэн тунхаглалуудыг авч үзлээ. Одоо бид гурав дахь хэсэг болох *Элч нарын тунхаг* дахь авралын тунхаглалыг үзэхэд бэлэн боллоо.

АВРАЛ

Элч нарын тунхгийн төгсгөлд авралын тухай олон зүйлийг хэлсэн байдаг. Авралын тухай яагаад заавал төгсгөлд байгаа юм бэ, өөр газар нь байж болоогүй юм байх даа гэж олон хүн асуудаг. Мэдээж тунхагт ч энэ талаар юу ч бичээгүй. Гэвч бид тунхгийг анхааралтай ажиглах юм бол энэ нь Бурханы тухай буюу Эцэг, Хүү, Ариун Сүнсний тухай эхэнд өгүүлснээрээ Аврал бол хүмүүний аливаа тогтолцоо ба санаа бодлоос биш харин зөвхөн Бурханаас ирнэ гэдгийг харуулдаг. Эцэг Бурхан, Хүү Бурхан, Ариун Сүнс Бурханыг таньж мэдэх нь гэм нүглээ гэмшин аврагдана гэсэн урилга ба амлалт уруу биднийг хөтөлдөг. Тиймээс бидний Бурхантай харилцах харилцааны үр жимс нь гурвалаар оршигч Бурхан чухам хэн бэ гэдэгт үндэслэн ургадаг болохыг харуулахын тулд авралын тухай ийнхүү төгсгөлд нь бичсэн гэж би бодож байна.

— Др. Стив Харпер

Тунхаг дахь итгэлийн үндсэн тунхаглалуудын сүүлчийн гурав нь авралын тухай байдаг. Энд гэм нүглийн уучлал, бие махбодын амилал, мөнхийн амийг ихэд онцлон дурддаг. Уламжлалт системт теологид амилалт ба мөнх амийн тухай ойлголтыг эскатологи буюу *эцсийн зүйлсийн* тухай онол сургаалд багтаан үздэг. Гэсэн ч энгийн ойлгомжтой байх үүднээс бид эдгээрийг аврал гэсэн сэдэв дор үзэх болно.

Бүх Христитгэгчид Есүс Христийн эвлэрүүллийн ажлаар гэм нүглийн уучлалыг хүлээн авдаг гэдэгт итгэдэг. Бид гэм нүглээ хүлээн зөвшөөрч, гэмшвэл Бурхан биднийг гэмээс маань болж шийтгэхгүй гэдэгт итгэдэг. Чуулган эхнээсээ л үүнд итгэдэг байсныг *Элч нарын тунхагас* бид харж болно. Бичвэр бидэнд Есүс

Христээр дамжуулан уучлагдсан хүн бүр мөнхийн амийг хүлээн авна гэж заадаг. Жишээ нь, Иохан 3:16-18 дээр биднийг урамшуулсан байдаг. Энд:

“Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан учраас цорын ганц Хүүгээ өгсөн. Тиймээс Хүүд итгэдэг хэн ч мөхөхгүй харин мөнх амьтай болно. ...Түүнд итгэдэг хүн яллагдахгүй...” гэжээ (Иохан 3:16-18).

Итгэгч бүр мөнх амийг хүлээн авсан. Сүнс маань шинэ амьтай болж, мөхөшгүй болдог тул мөнх амь итгэсэн тэр мөчөөс эхэлдэг.

Харин орчин цагийн итгэгчид тунхагт өгүүлсэн мөнх амины тухай сонсохдоо гайхаж орхидог. Ялангуяа, бие махбодын амиллын талаар ойлгохдоо Есүсийн үхлээс амилсан тухай ярьж байна гэж андуурдаг. Гэхдээ тийм биш ээ. Есүсийн амиллын тухай “гурав дахь өдрөө Тэрээр үхлээс амилсан” хэмээн тунхгийн эхэнд хэлсэн байдаг. Энэ ойлголтыг энд дахин давтаж хэлээгүй.

Харин энэ хэсэгт буй үхлээс амилна гэдэг нь Шүүлтийн өдөр бүх хүн үхлээс амилах тухай өгүүлдэг. Тэд биегүй сүнсээр биш харин махбодтой, бодит биетэйгээр мөнхийн хувь тавиландаа орно гэсэн библийн сургаалыг хэлж байгаа юм. Энэхүү сургаал нь библийн үнэн сургаал бөгөөд хэдэн мянган жилийн туршид чуулганы итгэлийн гол чухал ойлголт байсаар ирсэн. Есүс энэ тухай Иохан 5:28-29 дээр заасан байдаг. Энд:

“Булшинд байгчид бүгдээрээ Түүний [Хүүгийн] дууг сонсон гарч ирэх цаг ирж байна — Сайныг үйлдсэн нь амийн амилалд, муу муухайг үйлдсэн нь ялын амилалд байх болно” гэжээ (Иохан 5:28-29).

Авралын талаарх тунхаглалуудыг Бичвэрт тодорхой заасан байдаг бөгөөд библийг дагадаг чуулганууд эдгээрийг үргэлж хүлээн зөвшөөрсөөр ирсэн. Гэтэл өнөө цагт Христийг дагадаг гэдэг олон итгэгчид эдгээр үндсэн, суурь сургаалыг үгүйсгэдэг. Зарим хүмүүс Бурхан бидний гэм нүглийн төлөө бидэнтэй хариуцлага тооцохгүй гэж үзэн, уучлал өршөөл хэрэггүй гэдэг. Энэ амьдралаас өөр амьдрал байхгүй, бидэнд байгаа “мөнхийн” амь бол газар дэлхий дээр бие махбодоороо амьдарч буй хугацаагаар л хязгаарлагдана гэж заадаг үл итгэгч хүмүүс ч чуулгануудад бий. Мөн бид мөнхийн амьдралдаа бие махбодоор биш зөвхөн сүнсээрээ л тэнгэрийн улсад байна гэж итгэдэг олон хүн бий. Иймээс *Элч нарын тунхагт* зааж өгсөн итгэлийн үндсэн тунхаглалууд анхны зуунуудад чухал хамаатай байсан шигээ өнөөдөр ч бас тийм хэвээр байна.

Товчхондоо, *Элч нарын тунхаг нь* Бурханы тухай, чуулганы тухай мөн авралын тухай онол сургаалд төвлөрдөг гэсэн үг. Цуврал хичээлийнхээ дараа дараагийн хичээлээр бид эдгээр ойлголт тус бүрийг илүү гүнзгийрүүлэн судлах болно. Харин энэ хичээлээр та бүхэн эдгээр цөөн хэдэн үндсэн суурь, гол онол сургаалууд нь олон зуун жилийн туршид Христитгэлийн хүрээг тодорхойлсоор ирсэн гэдэг том зураглалыг ойлгох нь чухал.

Элч нарын тунхаг дахь итгэлийн үндсэн тунхаглалуудын тухай үзэхдээ бид тунхгийн түүх болон теологийг тоймлон ярилцлаа. Одоо бүгдээрээ гурав дахь гол сэдэв болох *Элч нарын тунхагт* дахь итгэлийн үндсэн тунхаглалуудын ач холбогдол одоо ч хэвээр байгаа тухай үзэхэд бэлэн боллоо.

АЧ ХОЛБОГДОЛ

Бид *Элч нарын тунхаг* дахь онол сургаалуудын ач холбогдлын гурван талыг авч үзэх болно. Нэгдүгээрт, эдгээр сургаалууд Христитгэлийн бусад теологийн үндэс суурь болдог тухай тайлбарлана. Хоёрдугаарт, эдгээр сургаалуудыг чуулган даяараа дэлхий дахинаа хүлээн зөвшөөрдөг тухай үзнэ. Гуравдугаарт, бид эдгээр итгэлийн үндсэн ойлголтуудын *нэгтгэх чанарын* тухай ярилцах болно. Ингээд одоо *Элч нарын тунхаг* дахь онол сургаалын үндсэн суурь чанаруудыг эхлээд ярилцацгаая.

ҮНДЭС СУУРЬ

Том барилга байгууламж нь бат бөх суурьтай байх ёстой гэдгийг хүн бүр мэднэ. Барилгын суурийг тавьсны дараа л барилга барих ажил эхэлдэг шүү дээ. Суурь нь сайн байвал барилга тогтвортой болж, бүхэл бүтэц нь бат бөх, тэсвэртэй болдог.

Ефес 2:19-21 дээр Паул сүм чуулганыг элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр байгуулагдсан барилгатай зүйрлэсэн байдаг. Түүний хэлсэн үгийг сонсоцгооё:

“Тэгэхээр та нар ... Бурханы гэр бүлийнхэн юм. Та нар элч нар ба эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь ажээ. Түүний дотор бүх барилга холбогдон Эзэн доторх ариун сүм болохоор өсөж байна” гэжээ (Ефес 2:19-21).

Чуулган нь бат бөх, үнэн суурьгүйгээр Бурханыг хүндэлдэг чуулган болж байгуулагдаж чадахгүй.

Яг үүний адилаар, Христитгэлийн теологи нь үнэн онол сургаал болон зарчим дээр суурилж байж л Бурханыг алдаршуулж, итгэгчдэд ашиг тусаа өгч чадна. Есүс бол чуулганы булангийн чулуу, Түүний сургаал бол теологийн булангийн чулуу мөн. Элч нар болон эш үзүүлэгчид Христийг хүн төрөлхтөнд танилцуулснаараа чуулганы суурь болсны адил, *Элч нарын тунхаг* нь Бичвэр дэх элч нарын сургаалыг бидэнд танилцуулснаараа теологийн үндэс суурь болсон юм.

Элч нарын тунхгийн нэг гайхалтай зүйл бол өнөөдөр дэлхий дахинд байгаа бүхий л урсгал чиглэлийн итгэгчдийн дагах ёстой Христитгэлийн үндсэн чухал онол сургаалуудыг маш сайн хураангуйлан нэгтгэж өгсөн явдал юм. Энд Бурхан гэж хэн бэ, Эзэн Есүс Христ гэж хэн бэ, Ариун Сүнсний ажил болон авралын болон чуулганы тухай онол сургаалд Ариун Сүнс ямар үүрэгтэй байдаг тухай өгүүлдэг. Цаашлаад энд эцсийн шүүлт болох хүртэлх зүйлс болон Эзэн Есүс Христийн хоёр дахь ирэлтийн тухай бий. Христитгэлийн эдгээр гол, үндсэн сургаалыг мэдэхгүйгээр

Христитгэгч байх боломжгүй.

— Др. Стефен Ж. Вэллум

Элч нарын тунхаг хэрхэн үндэс суурь болдог тухай бид хоёр хэсэгт хуваан үзэх болно. Нэгпүгээрт, бид тунхаг нь бусад онол сургаалыг шүүн үзэх стандарт болж чаддаг тухай үзнэ. Хоёрдугаарт, тунхаг нь бусад үнэн онол номлолын логик хэм хэмжээг тогтоож өгдөг үндсэн суурь болдог тухай ярих болно. Одоо бүгдээрээ Элч нарын тунхаг хэрхэн теологийн стандарт болдог тухай үзье.

Стандарт

Элч нарын тунхаг нь Христитгэлийн хамгийн чухал, томоохон ойлголтуудыг зааж өгдөг учраас онол сургаалын стандарт хэм хэмжээний үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээр ойлголтуудын тухай Бичвэрт тодорхой байдаг тул хүн бүр хүлээн зөвшөөрөх учиртай. Энэ хичээлийнхээ эхэнд хэлсэнчлэн тэдгээр сургаал нь Христитгэлд маш чухал байдаг. Тиймээс бидний хүлээн зөвшөөрдөг бусад бүх онол сургаалууд нь тунхагт заасан тэдгээр сургаалтай нийцэж байх ёстой. Өөрөөр хэлбэл бид тэдгээр гол сургаалуудтай зөрчилдсөн ямар ч ойлголтыг хүлээн зөвшөөрч болохгүй гэсэн үг юм.

Та өмнө нь вэнтрилоквист хүнийг харж байсан уу? Вэнтрилоквист гэдэг нь уруулаа огт хөдөлгөхгүйгээр ярьдаг жүжигчин хүнийг хэлдэг. Тэд ихэвчлэн хүүхэлдэйтэй үзүүлбэр үзүүлдэг бөгөөд хүүхэлдэй нь вэнтрилоквисттэй ярилцаж байгаа мэтээр жүжиглэдэг. Чадварлаг вэнтрилоквист нь хүүхэлдэйг амьд юм шиг санагдуулж чаддаг ч хүүхэлдэй нь биш вэнтрилоквист л ярьж байгааг бид мэддэг шүү дээ. Яагаад?

Үүний хариулт маш энгийн. Хүүхэлдэй нь амьд биш учраас л ярьж чадахгүй гэдгийг бид мэддэг. Тиймээс бид хүүхэлдэйг ярьж байхыг харахдаа үүнийг мэдэж байгаа үнэнийхээ стандартаар шүүн тунгаадаг. Гарцаагүй хүүхэлдэй нь ярьж байгаа мэт харагдаж болох ч бидний стандарт бидэнд харагдах байдал нь хуурмаг гэдгийг хэлээд өгдөг. Тэр хүүхэлдэй хэрхэн амьд юм шиг ярьж байгааг бид тайлбарлаж чадахгүй ч байж болно. Гэхдээ л бид үүнд бидний мэдэж байгаа стандартад нийцсэн ямар нэгэн тайлбар байх ёстой гэдгийг мэддэг шүү дээ.

Яг үүний адилаар, *Элч нарын тунхагт* бидний хэзээ ч өөрчлөхгүйгээр бат баримтлан зогсдог тэрхүү үндсэн гол итгэл үнэмшлүүдийг хураангуйлсан байдаг. Эдгээр ойлголт нь Библид тун тодорхой байдаг бөгөөд маш чухал тул бид өөрчилж болохгүй юм. Тиймээс Библийн эдгээр үндсэн сургаалуудтай зөрчилдсөн ямар ч ойлголт, үзэл санаанд бид итгэхгүй.

Бид тунхгийг стандарт болгосноор хуурамч багш нар худал теологидоо итгүүлэх гэж ятгах үед Бичвэрт үнэнч үлдэж чаддаг. Бидний ихэнх нь өөртөө итгэлтэй, хүчирхэг, бусдыг ятгаж чаддаг хүмүүстэй тааралдаж байсан байх. Тийм хүмүүсийн хэлсэн бүхэнд, бүр худал буруу ярьж байсан ч итгэж л орхидог. Тиймээс итгэл үнэмшлийн чухал зүйлсийн товч жагсаалттай байх нь яг л зангуутай мэт Библийн сургаалаас баттай зуурахад маань бидэнд тусалдаг. *Элч нарын тунхаг* бол яг л ийм зангуу шиг гэсэн үг.

Жишээ нь, чуулган түүхийнхээ эхэн үед хэд хэдэн томоохон гаж буруу урсгалуудтай нүүр тулсан байдаг. Тэдгээрийн нэг нь гностик үзэл юм. Гностик үзэл нь хүний бие махбод ёр муу гэж сургадаг ба аврал бол өөрсдийн сүнсээ тэрхүү махбодын шоронгоос чөлөөлөхийг хэлнэ гэж үздэг. Анхны чуулганы итгэгчид энэ буруу сургаалыг хэрхэн няцаахаа сайн мэдэхгүй байв. Харин *Элч нарын тунхгийн* онол сургаалаар сургагдсан итгэгчид Бичвэр дэх бие махбодын амиллын талаарх сургаалд үндэслэн уг гаж сургаалыг итгэлтэйгээр няцааж байв. Учир нь Бичвэрт Есүс бидний сүнсийг төдийгүй, бие махбодыг ч бүхэлд нь аврахаар ирсэн гэж заадаг.

Ихэнх хүмүүс ухаантай үгс ба худал тоо мэдээнд төөрөлдсөн байдаг. Бид эдгээр үгс ба нээлтүүдийн чухам юу нь буруу гэдгийг үргэлж тайлбарлаад байж чаддаггүй. Гэсэн хэдий ч *Элч нарын тунхагтай* зөрчилдсөн бүхнийг бид итгэлтэйгээр эсэргүүцэж болно. Учир нь тунхаг нь Бичвэрт бүрэн суурилсан гэдгийг бид мэддэг.

Мэдээж бид *Элч нарын тунхаг* эсвэл өөр ямар нэг тунхаглалыг Бичвэртэй эн тэнцүү гэж өргөмжлөх гэсэнгүй. Библи бол цор ганц туйлын үнэн билээ. Хэрэв *Элч нарын тунхаг дахь* итгэлийн үндсэн тунхаглалууд нь Бичвэртэй ямар нэгэн байдлаар зөрчилдсөн л байх юм бол эдгээрээс татгалзах ч боломжтой. Гэхдээ *Элч нарын тунхаг* чуулганы эхэн үеэс өдийг хүртэл цаг хугацааны шалгуурыг даван гарч чадсан юм. Энэ нь Библийг үнэн зөв танилцуулдаг гэдэг нь дахин дахин нотлогдсон. Тиймээс бид орчин цагт тулгарах олон онол сургаалыг шалгахдаа тунхгийг стандарт болгоход эргэлзэх зүйлгүй.

Бид *Элч нарын тунхаг* нь онол сургаалын стандарт болдог тухай үзсэн учраас одоо тунхгийн бас нэгэн үндсэн тал болох бусад теологийн үзэл санааны логик буюу учир зүйн үндэс болдог тухай үзэхэд бэлэн боллоо.

Учир зүйн үндэс

Аливаа үзэл санаануудын хоорондох учир зүйн холбоо нь яг л гол болон голын эх ундарга хоёрын хоорондын холбоотой адил байдаг. Учир зүйн үндсэн суурь санаанууд нь голын эх ундаргатай адил юм. Энэ нь бусад санаанууд урган гарах эх сурвалж болдог. Харин учир зүйн хамааралтай санаанууд нь ундаргаасаа эх аван урсаж буй голтой адил. Тиймээс нэг санаа бусад санааны учир зүйн үндэс болдог гэдэг нь тэр учир зүйн үндсэн санаанаас учир зүйн хамааралтай өөр санаанууд урган гардаг гэсэн утгатай.

Жишээлбэл, *Элч нарын тунхагт* Бурхан Эцэгийн тухай тун цөөн зүйлсийг өгүүлдэг. Эдгээр нь:

**“Би тэнгэр газрыг Бүтээгч,
Төгс хүчит Бурхан Эцэгт итгэдэг” гэжээ**

Гэвч эдгээр онол сургаал нь Эцэгийн талаарх бидний итгэдэг бусад олон зүйлсийн учир зүйн үндэс болдог. Жишээ нь, Бурхан бол *тэнгэр газрыг Бүтээгч* гэдэгт үндэслэн бид Бурхан бол тэнгэр газрын дээгүүрх эрх мэдэлтэй Нэгэн юм

гэдэгт зүй ёсоор итгэдэг. Ийнхүү анхны бүтээл нь нэн сайхан байсан тул бид байгаль дэлхийг хараад Бурханы тухай мэдэх боломжтой байдаг.

Учир зүйн үндсэн онол сургаалын үнэ цэнийг бид модтой зүйрлэж болно. Бичвэрийг бид модны хөрс шороо гэж бодож болох бөгөөд тэр хөрснөөс теологийн мод урган гардаг. Харин модны их бие болон гол мөчрүүд бол хамгийн гол үндсэн онол сургаалыг илэрхийлдэг. Тэдгээр нь зөвхөн Бичвэр дээр үндэслэж, Бичвэрээс хамааралтай байдаг. Харин гол мөчрүүдээс олон жижиг мөчрүүд салаалан ургасан байна. Тэдгээр нь гол мөчрүүдээс учир зүйн хувьд урган гарсан итгэл үнэмшлүүд юм. Харин модны навчис бол жижиг мөчрүүдээс хамааралтай санаанууд юм. Энэ зураглалаар харах юм бол *Элч нарын тунхаг* эхлэхийн үнэ цэнэ тодорхой болдог. Бид модны хэлбэр хэмжээг ойлгож, Бичвэрт бат үндэслэхийн тулд эхлээд том онол сургаалуудыг сурах нь зүйтэй.

Энэ нь бидэнд хоёр төрлийн ашигтай. Нэгдүгээрт, теологийн үзэл дэх олон өөр төрлийн итгэл үнэмшлүүдийн хоорондын хамаарлыг олж харахад тусалдаг. Хоёрдугаарт, энэ нь бидэнд үндсэн биш санаануудыг үндсэн итгэл үнэмшилтэй уялдуулах замаар Бичвэрээс алс хол онол сургаалуудыг олж харахад тусалдаг.

Элч нарын тунхаг дахь онол сургаалууд нь Христитгэлийн үнэний гол цөмийг хэлбэржүүлж өгдөг. *Элч нарын тунхаг* нь үнэхээр хоёрдугаар зуунаас үүсэлтэй бөгөөд хэд хэдэн хэлбэртэй байж байгаад эцэст нь өнөөдрийн бидний ашиглаж буй энэ хэлбэрийг олсон юм. Энэхүү тунхагт *Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвалын тухай* байна. Мөн *Эзэн Есүсийн биежилт, золиос болсон үхэл, ялгуусан амилалт болон эргэж ирэх тухай* байна. Гэм нүглийн уучлал байна. Мөн энд бодит чуулган болох Христ дотор дахин төрсөн итгэгчдийн нөхөрлөл байна. Ямар ч сүм чуулган *Элч нарын тунхгийг* үе үе судалж, сургаал номлолыг нь анхаарч байхаас илүү эрүүл зүйл байхгүй гэж би бодож байна.

— Др. Ж. И. Пакер

Бид *Элч нарын тунхгийн* үндсэн мөн чанарыг авч үзлээ. Одоо тунхгийн сургаалын дэлхий дахины баталгааг тайлбарлахад бэлэн боллоо.

ДЭЛХИЙ ДАХИН

Аливаа баримтын үнэнийг шүүх нэг арга бол гэрч нарын хэлсэн зүйлсийг авч үзэх явдал байдаг. Тухайн баримтыг үнэн гэдгийг хэдий чинээ олон гэрч нотолно төдий чинээ бид түүнд итгэх магадлал өндөр байдаг. Теологид ч мөн адил яг ийм зарчим үйлчилдэг. Бид юунд итгэх вэ гэдгээ тодорхойлох гэж оролдох нь түүхийн туршид хүмүүс юунд итгэж ирсэн, мөн өнөө цагт хүмүүс юунд итгэж байна гэдгийг мэдэхэд тусалдаг. *Элч нарын тунхгийн* тухайд үүг дэх онол сургаалын тунхаглалуудыг дэлхийн ихэнх газар, ихэнх итгэгчид хүлээн зөвшөөрсөөр ирсэн байдаг.

Бид *Элч нарын тунхаг* дахь итгэлийн үндэсний тунхаглалуудын дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн мөн чанарыг түүхийн гурван цаг үед хуваан үзнэ. Нэгдүгээрт, эдгээр итгэл үнэмшлүүд нь Шинэ Гэрээнд үндэслэгдсэн болохыг үзнэ. Хоёрдугаарт, эдгээрийг дийлэнх Христитгэгчид чуулганы түүхийн туршид хүлээн зөвшөөрсөөр ирсэн болохыг харна. Гуравдугаарт, эдгээр нь өнөө цагт чуулганы дүр төрхийг хэрхэн тодорхойлсоор байгааг тус тус судлах болно. Юун түүрүүнд эдгээр онол сургаалуудын талаарх Шинэ Гэрээн дэх хувиршгүй баталгааг эхлээд үзэцгээе.

Шинэ Гэрээ

Анхны Чуулганы үеэс л Христ болон Түүний элч нарын сургаалын талаар маргаан гарсаар ирсэн. Зарим маргаан нь чуулганы гаднаас байсан бол зарим нь чуулганы дотроос гарсан байдаг. Жишээ нь, Галат 5-р бүлэгт бичсэнчлэн Паул харь үндэстний итгэгчдийг хозлуулахыг шаарддаг байсан Иудейн Христитгэгчдийг байнга эсэргүүцэн бичдэг байв. Мөн 2 Петр 2-р бүлэгт, Петр чуулганд хуурамч номлогчид гарч ирэх тухай анхааруулсан байдаг. Есүс болон Түүний элч нар янз бүрийн хүмүүсийн буруу ойлголтыг засаж байгаа жишээ Шинэ Гэрээгээр дүүрэн байдаг.

Чухал итгэл үнэмшлүүд эрсдэлд ордог учраас чуулганы доторх буруу ойлголтууд маш аюултай. Тиймээс Есүс болон Шинэ Гэрээний бичээчид теологийн суурь ойлголтуудыг засаж залруулахад ихээхэн анхаарч байсан нь ийм учиртай. Гайхалтай нь тэдний засаж залруулахаар хэлж буй үгс бие биетэйгээ яв цав нийцсэн байдаг. Тэр цаг үед чуулганд байсан хуурамч сургаалуудыг эс тооцвол Шинэ Гэрээ бидэнд алдаа мадаггүй, нэгдмэл нэгэн цул сургаалыг танилцуулсан юм.

Чуулган тэдгээр номуудаас бүрдсэн библийн каноныг бүрдүүлэхэд үнэндээ хэдэн зуун жилийг зарцуулсан. Энэ нь хурдан үйл явц байгаагүй. Үүнээс харахад чуулган үндсэн гол нэгдмэл зүйлийг аяндаа олж харсан гэсэн үг. Энэ бол тийм ч амархан дүгнээд орхичих зүйл биш бөгөөд үнэн хэрэгтээ 2000 гаруй жилийн туршид судлаачид энэ дүгнэлтийг баталсаар ирсэн байдаг. Гэхдээ Шинэ Гэрээний номуудын нэгдмэл байдлыг ярихдаа бид тэдгээрийн хоорондох ойлголт, харах өнцгийн ялгааг мөн хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энд яригдаж буй гол асуудал нь харах өнцөг ялгаатай хэдий ч онол сургаалын хувьд зөрчилдөхгүй байдаг явдал юм. Та бүхэн үүнээс өөр өөр харах өнцөг, өөр онцлог зүйлс болон бодит байдлыг өөр арга замаар, өөр талаас нь тусгасан байдгийг хардаг. Гэсэн хэдий ч миний бодлоор Шинэ Гэрээний тэдгээр олон янзын номуудын хооронд ямар ч илэрхий зөрчилдөөн байхгүй гэж харж байна.

— Др. Давид Р. Бауэр

Энэ л нэгдмэл байдлын ачаар Шинэ Гэрээ нь *Элч нарын тунхаг* дахь итгэлийн үндсэн тунхаглалуудыг батлах үед тунхаг нь дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн гэж хэлэх нь зөв зүйтэй болдог. Тэр үед Бурхан Эцэг, Хүү, Ариун Сүнсний тэнгэрлэг

байдлын тухай байнгын маргаан гардаг байсан хэдий ч Нэг л Бурханд бүгд итгэн дагадаг байсан. Сайнмэдээ нь Христийн талаарх ойлголт буюу Түүний төрөлт, амьдрал, үйлчлэл, үхэл ба амилал мөн тэнгэр өөд одсон талаарх тунхгийн баримтуудыг тусгадаг. Шинэ Гэрээний номууд нь бүхэлдээ тунхаг дахь чуулган ба авралын талаарх ойлголтуудыг бүрэн дэмждэг.

Ингээд бид Шинэ Гэрээний тухай авч үзлээ. Одоо эдгээр итгэл үнэмшлүүд нь чуулганы түүхийн туршид дэлхий дахинд Христитгэлийг хэрхэн тодорхойлж ирснийг харцгаая.

Чуулганы түүх

Шинэ Гэрээний үеийн сүм чуулгануудын л адил хожмын үеийн чуулгануудад ч бас олон янзын теологи бий болж байв. Маш олон жижиг асуудлууд дээр нэгдмэл байдал бараг байхгүй байсан гэж хэлж болно. Харин *Элч нарын тунхаг* дахь итгэлийн үндсэн тунхаглалууд гэх мэт үндсэн суурь онол сургаалуудыг бол бараг дэлхий даяараа бүгд батлан, хүлээн авсан юм. Харин үндсэн итгэл үнэмшлийг үгүйсгэсэн тохиолдолд чуулган түүхийн туршид маш хүчтэйгээр тэрс үзэл гэж үзэж, хагалан бутаргагч, хуурамч багш нар гэж тооцдог байсан.

Ганц жишээ дурдвал, МЭ 4-р зууны үеийн үйл явдлуудыг эргэн санацгаая. *Элч нарын тунхгийн* анхны хувилбаруудыг аль хэдийн ашиглаад эхэлсэн байсан үе. Түүхийн цаг үед хэд хэдэн буруу сургаал номлол үүсэж, чуулган зөвлөлийнхөө хамтаар шийдвэрлэсэн байдаг. Эдгээр зөвлөлүүдийн зарим нь нутгийн зөвлөлүүд, зарим нь дэлхийн ихэнх чуулганы бишопуудыг хамруулсан тул дэлхийн хэмжээний зөвлөл байсан гэж үздэг. Жишээ нь, МЭ 325 онд Никаиагийн Зөвлөл болон МЭ 381 онд Константиноплын Зөвлөл нь *Элч нарын тунхаг дахь* итгэлийн үндсэн тунхаглалуудтай холбоотой хэд хэдэн асуудлуудыг авч үздэг дэлхий хэмжээний зөвлөлүүд байв.

Орчин цагийн Никаиагийн тунхгийг МЭ 325 онд Никаиагийн Зөвлөл ноороглон гаргаж, улмаар МЭ 381 онд Константиноплын Зөвлөл үүнийг боловсронгуй болгож, орчин цагийн хувилбарыг гаргасан байна. Энэ бол *Элч нарын тунхгийг* улам дэлгэрэнгүй тайлбартай болгосон хувилбар юм. Гол зорилго нь тунхгийн зарим санааг худал тайлбарласныг залруулах явдал байжээ.

Жишээ нь, гностик үзэл нь энэ дэлхийг бүтээсэн Библийн Бурханыг өөр нэг бурхан бүтээсэн гэж заадаг байсан. Гностик үзэл шиг тэрс үзлүүдийг *Элч нарын тунхагаар* шууд няцааж болохгүй байсан учраас Никаиагийн тунхагт илүү дэлгэрэнгүй тайлбар оруулсан юм. Энэ нь *Элч нарын тунхгийн* санааг тодорхой болгох зорилготой байв.

Ялангуяа *Элч нарын тунхагт* “Би тэнгэр газрыг Бүтээгч Бурхан Эцэгт итгэдэг” гэсэн байхад, Никаиагийн тунхагт илүү дэлгэрэнгүй байдаг. Энд: “Бид тэнгэр газрыг, үзэгдэх ба үл үзэгдэх бүхнийг бүтээгч, цорын ганц Бурхан, Хүчит Эцэгт итгэдэг” гэжээ. Энд дөрвөн зүйл анхаарал татдаг:

Нэгдүгээрт, *Никаиагийн тунхаг* нь *Элч нарын тунхаг* дээр үндэслэсэн. Дэлхийн хэмжээний Никаиагийн Зөвлөл нь өөрсдийн тунхгийг *Элч нарын тунхагт* тулгуурласнаараа үүнийг чуулган дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч буйг харуулсан юм.

Хоёрдугаарт, *Никаиагийн тунхаг* нь “Би” гэдэг үгийн оронд “Бид” гэдэг үгээр эхэлдэг. *Элч нарын тунхаг* нь хувь хүн баптисм хүртэх үедээ итгэлээ тунхаглах зориулалттай байсан бол *Никаиагийн тунхаг* нь яг ижил онол сургаалыг даяар чуулган хамтдаа хүлээн зөвшөөрдөг гэсэн мэдэгдэл байв.

Гуравдугаарт, *Никаиагийн тунхаг*т “Бурхан” гэдэг үгийн өмнө “цорын ганц” гэдэг үгийг нэмж, тодотгож өгсөн байдаг. Ингэснээр Цорын ганц Бурхан байдаг гэсэн *Элч нарын тунхгийн* гол санааг илүү тодорхой болгосон.

Дөрөвдүгээрт, *Никаиагийн тунхаг*т Бурхан үл үзэгдэх буюу сүнслэг зүйлсийг оруулаад бүгдийг бүтээсэн гэдгийг тайлбарласан. Ингэснээр Бурханыг хэн ч бүтээгээгүй гэдэг санааг тодорхой болгосон. Дахиад л үнэндээ энэ санаа далд хэлбэрээр *Элч нарын тунхаг*т байсныг *Никаиагийн тунхаг*т илүү ил тод болгосон хэрэг байв.

Энэ төрлийн тайлбар, тодруулгуудыг бусад зөвлөлүүд болон теологичид ч олон зууны туршид санал болгосоор ирсэн. Заримдаа зөвлөлүүдийн шийдвэрийг бүх чуулган хүлээн зөвшөөрөхгүй байх явдал ч мэр сэр байв. Нэг зөвлөл зарим чуулганы үзэл бодлыг эсэргүүцнэ. Өөр нэг зөвлөл бусад чуулгануудын үзэл санааг эсэргүүцнэ. Энэ мэтээр санал зөрөлдөх тохиолдол цөөнгүй байсан ч бүгд *Элч нарын тунхгийн* үндсэн зарчмуудыг хүлээн зөвшөөрсөөр байсан юм.

Энэхүү шалтгааны улмаас л *Элч нарын тунхгийг* Христитгэлийн хамгийн үндсэн, дэлхий дахины тунхаглал гэж үздэг. Түүхийн туршид *Никаиагийн тунхгийг* л *Элч нарын тунхаг*т дүйцэхүйц, дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тунхаг гэж тооцдог. Гэхдээ *Никаиагийн тунхаг* нь тийм ч үндсэн зүйлсийг агуулдаггүй. Үүнд теологичид хүртэл заримдаа ойлгоход хүндрэлтэй хэд хэдэн теологийн ойлголтууд байдаг. Тиймээс л бид Христитгэлийн үндсэн суурь онолыг судлахын тулд *Элч нарын тунхгийг* сонгон авсан байдаг.

Ингээд бид энэ хүртэл Шинэ Гэрээ нь *Элч нарын тунхгийг* дэлхий дахинаа хүлээн зөвшөөрдөг тухай, мөн чуулганы түүхийн туршид дэлхий даяар энэ тунхгийн онол сургаалыг ашиглаж ирсэн талаар ярилцлаа. Тэгэхээр одоо бүгдээрээ өнөө цагийн тухай буюу эдгээр ижил итгэл үнэмшлүүд нь одоо ч Христийн чуулганыг тодорхойлсоор байгаа тухай үзэхэд бэлэн боллоо.

Өнөө цаг

Түүхийн бүхий л цаг үед хуурамч багш нар чуулганы зуун зуун жилийн туршид баримталж ирсэн үндсэн итгэл үнэмшлийг үгүйсгэсээр ирсэн. Орчин цагт Ёховагийн гэрчүүд болон Мормон гэх мэт гаж урсгалууд Библийг хүлээн зөвшөөрч, Христийг ямар нэгэн байдлаар дагахыг оролдсоноороо өөрсдийгөө Христитгэгчид гэж үздэг. Гэвч тэд бол жинхэнэ Христитгэгчид биш. Яагаад гэвэл тэд Христитгэлийн хил заагийг хоёр мянга гаруй жил тогтоож ирсэн *Элч нарын тунхаг* дахь итгэлийн үндсэн тунхаглалуудыг үгүйсгэдэг юм. Гаж буруу урсгалд тооцогддоггүй зарим чуулганууд хүртэл Христийн чуулганы зарим багш нарын адил үндсэн сургаалуудыг үгүйсгэдэг.

Тэгвэл *Элч нарын тунхаг* дахь итгэлийн үндсэн тунхаглалуудыг ийм олон хүн үгүйсгэдэг юм бол бид тунхаг нь өнөө цагийн чуулганыг бүхэлд тодорхойлдог гэж хэрхэн хэлэх вэ? Үүний хариулт нь хоёр талтай. Нэг талаас Христитгэлийн гэж тооцогддог сүм чуулганы дийлэнх нь тунхгийг хүлээн зөвшөөрдөг. Баптист, Методист, Лютеран, Англикан, Пресбитериан гэх мэт бүх төрлийн Протестант урсгалын сүм чуулганууд тунхагт итгэн дагадаг. Мөн Ромын Католик, Зүүний Ортодокс гэх мэт Протестант биш томоохон чуулганууд ч тунхгийг хүлээн зөвшөөрдөг.

Нөгөө талаас тунхгийн онол сургаалыг үгүйсгэдэг чуулгануудыг “Христитгэлийнх” гэж нэрлэх ёсгүй. Учир нь тэд Библийг хүлээн зөвшөөрч, Христийг дагадаг гэдэг ч, үнэндээ Бичвэрийн ба эртний чуулганы сургаалыг хүлээн зөвшөөрдөггүй. Тиймээс тэд бол жинхэнэ Христитгэгчид биш юм.

Тэгэхээр Элч нарын тунхагт агуулагдаж буй онол сургаалын ач холбогдлын тухай бодож үзье л дээ. Эдгээр нь чуулганы амьдрал, сайнмэдээний талаарх бидний ойлголт, мөн Христ доторх авралын талаарх ойлголтод маань туйлын чухал байдаг. Жишээ нь, тунхаг нь бидэнд Бурхан бол Эцэг, Бурхан бол Хүү, Бурхан бол Ариун Сүнс юм гэсэн Бурханы Гурвалын мөн чанарыг танилцуулдаг. Тиймээс бид өөрсдийгөө Христитгэгч гэж боддог хэр нь, Гурвалын тухай онолыг итгэлийн маань нэг жижигхэн хэсэг, итгэлд маань нэг жаахан “хүч” өгдөг зүйл юм шигээр хандаж болохгүй. Гэтэл Гурвалын тухай онол бол бидний Бурхан чухам хэн болох, хэрхэн оршдог талаарх тунхаглал юм шүү дээ.

— Др. Стив Блэйкмор

Элч нарын тунхгийн онол сургаал бол Христитгэлийн үндсэн, чухал суурь гэж би хэлмээр байна. Тэр үндсэн сууриас та холдвол Христигэлийн түүхэн итгэл үнэмшлээс холдож байна л гэсэн үг. Эртний чуулган Библийг тайлбарлах бүхий л төрлийн аргыг туршиж үзээд, “Энэ л зөв зам юм байна” гэж олж мэдсэн гэсэн үг. Энэ бол тэдний туулж гарсан зүйл. Энэ бас яг төмөр замтай адил. “Энэ бол Библийг тайлбарлах зөв зам” гэж заасан замаар нь явна гэсэн үг. Харин хэрэв өөр замаар явбал Христитгэлээс холдоно гэсэн үг. Өнөөг хүртэл Элч нарын тунхаг нь жинхэнэ Библид суурилсан итгэлийн үндсэн чухал мөн чанарыг тодорхойлсоор ирсэн юм.

— Др. Петр Волкер

Элч нарын тунхагт хураангуйлан танилцуулсан итгэл үнэмшлүүд нь хамгийн үндсэн бөгөөд дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн байдаг тул итгэгчдийг улам нэгдмэл болгодог. Орчин цагийн чуулганд хуваагдал маш их байгаа учраас энэ л чанар өнөөдөр ч онцгой үнэ цэнтэй юм.

Нэгдэл

Чин бишрэлтэй хэр нь онол сургаал нь Христитгэгчдийг хагаран бутаргадаг гэж үздэг учраас теологи сурахаас зайлсхийдэг итгэгчтэй та тааралдаж байсан уу? Тийм хүмүүс теологи судлахаас зайлсхийж буй энэ үзлээ “Есүс биднийг нэгтгэдэг, харин онол биднийг хуваадаг” гэсэн үгээр хамгаалдаг. Гэвч энэ үзэл нь үнэний ортой. Христитгэгчид онолын ялгаатай байдлаас болж олон үеийн туршид хагаран бутарч, бие биеэ шүүж, яллаж, дайн хүртэл хийж байсан. Хэдий тийм ч Шинэ Гэрээ нь чуулганыг онол сургаалын хувьд нэгдмэл байхыг урамшуулсаар байдаг. Жишээ нь, Ефес 4:11-13 дээр энэ тухай бичсэн байдаг. Энд:

“Тэр [Есүс], заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайнмэдээ тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгосон нь ...Христийн биеийг байгуулахын тулд юм. Бид бүхэн итгэл ба Бурханы Хүүг мэдэх мэдлэгийн нэгдэл рүү, төлөвшсөн хүн болтлоо, Христийн дүүрэн чанарын хэмжээнд хүртлээ ингэх ажээ” гэсэн байна (Ефес 4:11-13).

Энэ багц эшлэлд Паул чуулганыг Христийн бие гэж тодорхойлсон байна. Мөн тэрээр чуулган нь итгэл ба мэдлэг дотор нэгдэхээс нааш Христ дотор төлөвшиж чадахгүй гэж тодорхой хэлжээ. Тиймээс онол сургаалын хувьд нэгдмэл байх нь Христитгэгч нэг бүрийн зорилго байх учиртай.

Мэдээж Христитгэгч хүний амьдралын өөр олон хүчин зүйлс онол сургаалыг судлахад маань нөлөөлнө. Бид Бурханыг болон хөршөө хайрлаж, ариун байдлыг сахиж, Ариун Сүсний хүч чадалд түшиглэн, Бурханы үгийг тунгаан бодож байх нь бидний нэн тэргүүний хийх ёстой зүйл мөн. Харин зөвхөн онол сургаалд л анхаарч бусад зүйлсээ орхивол, буруу замаар амархан ордог.

1 Коринт 13:2 дээр элч Паул энэ тухай анхааруулахдаа:

“Хэрэв би ... бүх нууц болон бүх мэдлэгийг мэддэг байгаад ... надад хайр үгүй бол би юу ч биш” гэжээ (1 Коринт 13:2).

Энэ эшлэл болон өөр олон хэсэгт дурдсанчлан теологийн мэдлэгтэй болох нь чухал ч, Христитгэлийн хамгийн чухал нь биш гэдгийг тодорхой өгүүлдэг.

Теологийн зөрчлийн үр дагавраас зайлсхийх хамгийн үр дүнтэй арга бол дэлхий даяарх Христийн бүх дагалдагчдын санал нийлдэг онол сургаалын нэгдмэл байдлыг эрхэмлэх явдал юм. Теологийн нарийн зүйлсийг тэнцвэртэйгээр судлахдаа нэгдмэл байдлыг чигээ болгож чадвал, онол сургаал биднийг хагаран бутаргахаас илүүтэй нэгтгэх чадах билээ.

Есүс Христийн чуулганд өнөөдөр нэгдмэл байдал юунаас ч илүү

хэрэгтэй байна. Бид олон урсгалд хуваагдаж, Ариун Сүнс, баптисм, эмэгтэйчүүд гээд л олон зүйл дээр өөр өөр үзэлтэй болжээ. Тэгсэн мөртөө энэ 21-р зуунд бид *үнэн* дээр гэхээсээ илүү дэлхийд хүрэх гэх мэт *үйлдэл* дээрээ л нэгдмэл байхыг анхаардаг болчихсон байгаа юм. Харин бидний Эзэн Есүс болон элч Паул нарын нэгдмэл байдлын талаарх санаа бодол их сонирхолтой. Би Иохан 17 болон Ефес 4 -р бүлгийг бодож байна л даа. Бид нэг Бурхан, нэг Эзэн, нэг Ариун Сүнс, нэг итгэл, нэг баптисмтай учраас нэгдмэл байх учиртай гэж тэд бодож байсан. Тиймээс бид үнэнийг, үнэн гэж итгэдэг зүйлээ л Христ дотор нэгдмэл байх үндэс суурь болгох учиртай юм.

— Др. Самуэл Лин

Дэлхий даяар Христийн олон зуун сая дагалдагчид *Элч нарын тунхаг* дахь библийн үндсэн сургаалыг тууштай баримталдаг. Мөн үнэн хэрэгтээ яг энэ цаг мөчид ч тоо томшгүй олон итгэгчид ийнхүү тууштай баримталсныхаа улмаас хавчигдаж, түүгээр ч зогсохгүй амиа алдсаар байна. Тэд теологийн олон асуудал дээр бие биетэйгээ санал нийлэхгүй байж болно. Үнэн хэрэгтээ тэд та бидний баттай итгэдэг зүйлийг хүчтэй эсэргүүцдэг байж ч болно. Гэвч ялгаатай байдлаасаа үл хамааран бид тунхаг дахь Бурхан болон чуулганы тухай мөн авралын тухай заасан зүйлст хамтдаа нэгдэн зогсдог. Иохан 17:23 дээр Есүс чуулганы төлөө юу гэж залбирсныг эргэн санацгаая. Энд:

“Би тэдний дотор, Та Миний дотор. Ингэснээр тэд бүрэн төгс нэг болж, Та Намайг илгээсэн, Намайг хайрласны адилаар тэднийг хайрласныг ертөнц мэдэх болно” гэжээ (Иохан 17:23).

Чуулганы нэгдмэл байдал бол Өөрийг нь Эцэг илгээсний баталгаа гэж Есүс энд хэлснийг анзаарав уу. Бид Христийн бусад дагалдагчидтай мөр зэрэгцэн зогсож, теологийн ижил итгэл үнэмшилтэй байж чадвал энэ дэлхийд сайнмэдээг үнэн гэдгийг гэрчилж, сайнмэдээ түгээх үйлсээ хүчирхэгжүүлж чадна.

Сайнмэдээг тодорхойлж, сайнмэдээний үндсэн суурь итгэл үнэмшлийг санаа нийлэн дагаснаар л бид эв нэгдмэл ба үнэнийг олж чадна. Сайнмэдээний талаар тууштайгаар нэгдмэл байж чадвал амьдрал дээрээ ч, үйлчлэл дээрээ ч өөр хоорондоо нэгдмэл байж чадна. Мөн тэгж байж л бид бие биеийнхээ үнэн гэж итгэдэг зүйлсийг эсэргүүцэхгүй, харин ч бие биеийнхээ ялгаатай байдалд баярлаж, хүндэтгэлтэйгээр бас ухаалгаар ялгаатай байж, бүр ялгаатай талуудаа хайрлаж чадна. Хамгийн гол нь бид үнэн болон итгэл дээрээ адил зүйлст баярлаж байхыг эрмэлзэх хэрэгтэй. Тодорхой хэмжээнд бид адил зүйлсийг хуваалцаж байх ёстой. Тэгж байж л бид нэгдлийг мэдэрч, теологийн итгэл үнэмшлийн хувьд үнэн зөвөөр бас ухаалгаар ялгаатай байж чадна.

— Др. Ж. Лигон Дункан III

Элч нарын тунхаг нь Христитгэгчдэд итгэлийн үндсэн гол чухал зүйлсээ чухал биш зүйлсээс ялгахад нь тусалдаг. Тунхгийг бид хувийн болон чуулганы хамтын амьдралд чухалчилснаар теологи нь биднийг хагаран бутаргахгүй гэдгийг ч харах болно. Харин ч бид Христийн бусад итгэмжит дагалдагч нартай нэгдэж, нэг болсноор Есүсийн Өөрийн чуулганахаа төлөөх тэрхүү алсын харааг гүйцэлдүүлж чадна юм.

ДҮГНЭЛТ

Энэ хичээлээр бид *Элч нарын тунхаг* дахь итгэлийн үндсэн тунхаглалуудыг танилцуулж, тунхгийн хөгжил ба зорилгын түүхэн замналын тухай ярилцлаа. Мөн бид тунхаг дахь Бурхан, чуулган болон авралын талаарх онол сургаалыг тоймлон үзлээ. Тунхагт багтсан итгэлийн үндсэн тунхаглалуудын ач холбогдлын тухай үзэхдээ тэдгээрийн үндэс суурь, дэлхий дахины болон нэгтгэдэг мөн чанартай танилцсан билээ. *Элч нарын тунхаг* бол зуу зуун жилийн турш Христитгэлийн үндсэн гол итгэл үнэмшлийг хураангуйлан нэгтгэсэн, түүхийн маш чухал баримт бичиг юм. Энэ нь өнөө цагт ч Христитгэлийн урсгал чиглэл бүрийн теологичдыг нэгтгэхэд тун чухал үүрэгтэй хэвээр байна. Энэхүү цуврал хичээлийн дараа дараагийн хичээлээр бид *Элч нарын тунхагт* багтсан итгэлийн үндсэн тунхаглалуудыг илүү дэлгэрүүлж үзэх болно. Тэдгээр нь дэлхий даяарх Христитгэлийн сургаал номлолыг нэгтгэдэг Библийн үнэнийг хэрхэн илэрхийлдэг болохыг нарийвчлан ярилцана.

ХАМТРАГЧИД

Др. Ван Гэйтон (хөтлөгч) бол Виллиамс Библийн Институтийн салбарын захирал, дэлхий даяарх өөр олон сургалт болон их сургуулиудад Библийн багш, илтгэгч. Др.Гэйтон нь мөн Холбооны Шоронгийн товчооны эрхлэгчээр 4 жил үйлчилсэн. Мөн Вашингтоны Шашин ба Олон нийтийн бодлогын институтын захирлуудын зөвлөлд байсан. Др.Гэйтон нь Олон улсын Семинар сургуулийн Теологийн мастер, Логос Библийн Коллежээс Шашны мастер, Христитгэлийн Удирдлагын Их Сургуулийн Библийн философийн доктор, Фэйт теологийн семинарийн Теологийн доктор, Реформэд теологийн семинарын Үйлчлэлийн доктор зэргийг тус тус хамгаалжээ. Мөн тэрээр Апостолик Саксэшинд бишпоор томилогдож байсан. Христийн Биеийн түүхэн нэгдлийг сэргээх зорилготой Христитгэлийн чуулгануудын Олон улсын Коммунигтийн Аркбишпоор үйлчилж байсан.

Др. Дэвид Р. Бауэр бол Библийн орчуулгын Сургуулийн салбарын захирал ба Асбури Теологийн Семинарын Индактив Библийн судлалын Ралф Валдо Бийсон Профессор.

Др. Стив Блейкмор бол Вэсли Библийн Семинарын философийн туслах Профессор.

Др. Паул Чанг бол Нью Жерсигийн Монмауф Хятадын Христитгэлийн Чуулганы Ахлах пастор.

Др. Ж. Лигон Дункан III бол Реформэд теологийн семинарын Канселлор, CEO ба Системт болон Түүхийн Теологийн Жон И. Ричардсийн Профессор.

Др. Стив Харпер бол ФЛ, Орландо дахь Асбури Теологийн Семинарын Флорида - Дуннам кампусын үндэслэн байгуулагч, дэд Ерөнхийлөгч. Сүнслэг байгуулал болон Весли судлалын тэтгэвэрт гарсан профессор.

Др. Риад Кассис бол Эвангелийн Теологийн Боловсролын Олон Улсын зөвлөлийн Олон улсын удирдагч.

Др. Самуэл Линг бол Хятад Хоризоны хамтран үүсгэн байгуулагч.

Др. Роберт Ж. Листер бол Теологийн Талбот Сургуулийн Библийн болон Теологийн судлалын туслах профессор.

Др. Р. Алберт Мохлер, Жр. Бол Саунтерн Баптист теологийн семинарын Ерөнхийлөгч.

Др. Жон Освалт бол Асбури теологийн семинарын Хуучин Гэрээний хүндэт зочин профессор.

Др. Ж. И. Пакер (1926-2020) нь Британийн Колимб, Ванкуверын Режент Коллежийн Говернорс Зөвлөлийн профессор агсан ба Их Британи болон Америкт алдартай номлогч, илтгэгч байсан.

Др. Ионатан Т. Пеннигтон бол Саунтерн Баптист теологийн семинарын Шинэ Гэрээний орчуулгын туслах профессор ба Докторын судалгааны захирал.

Др. К. Эрик Тоеннос бол Байола Их Сургуулийн Талбот Теологийн сургуулийн Библийн болон теологийн судлалын профессор ба Теологи салбарын библийн ба теологи судлалын захирал.

Др. Петр Волкэр Үйлчлэлийн Трини Сургуулийн библи судлалын профессороор үйлчилж байсан. Оксфорд, Вайклиф Холлын туслах дэд эрхлэгч. Библи судлалын Иерусалим Төвийн захирлаар ажиллаж байгаа.

Др. Стефен Ж. Вэллум бол Өмнөд Баптист теологийн сургуулийн Христитгэлийн теологийн профессор.

ҮГСИЙН ТАЙЛБАР

Элч, элч нар – Есүсийн анхны 12 дагалдагч

Апостолик/апостоликал – Элч нарын, элчит буюу тэдэнтэй холбоотой

Августин – Хиппогийн Бишоп (МЭ. 354-430 он). Тэрээр Бичвэр бол онол сургаалын эцсийн дээд эрх мэдэл гэж итгэдэг байсан бөгөөд тунхгийг чуулганд ашигтай библийн сургаалын хураангуй гэж үзсэн. Мөн тэрээр өнөөгийн чуулганд одоо ч нөлөөлсөөр байгаа олон бүтээл бичсэн

Кайсирын Базил – МЭ 370 онд сонгогдсон Кайсирийн бишоп (МЭ. 330-379 он). Библи бол онол сургаалын эцсийн дээд эрх мэдэл гэж хамгаалдаг байсан

католик – "дэлхий дахины" гэсэн утгатай үг. Элч нарын тунхагт чуулган гэдгийг бүх үеийн, бүх газрын, бүх итгэгчид гэдэг утгаар тодорхойлоход ашигласан

Христ – Грек хэлний "хритос" гэдэг үгнээс гаралтай ба "тослогдсон" эсвэл "тослогдсон нэгэн" гэсэн утгатай. Хуучин Гэрээний Еврей хэлний "мессиа" гэдэг үгтэй нягт холбоотой

Сиприан – Гуравдугаар зууны үеийн Картейжийн бишоп (са. МЭ. 200-258 он). Чуулганы уламжлалт сургаал нь Бичвэрээс дээгүүр эрх мэдэлтэй байж болохгүй гэж бичсэн нэгэн

Докетист – Христийн хүн мөн чанарыг нь үгүйсгэдэг буюу бодит бие махбодгүй зөвхөн хүний дүрээр харагддаг байсан гэж үздэг гаж буруу урсгал

Экклесиастикал – сүм чуулгантай холбоотой, зохион байгуулалттай нэгдэл

мөнхийн амь – Бурханыг таньж мэдэж, Бурханы бүрэн дүүрэн ерөөлд үүрд мөнх амьдрах

Гностисизм – Христийн дараа анхны зуунд гарч ирсэн гаж сургаал. Хүний бие махбодыг оролцуулаад материаллаг аливаа зүйлс ёрын муу гэж үздэг байсан. Тиймээс Бурхан хэзээ ч хүний биед төрөхгүй учир Есүс Бурхан бас хүн байгаагүй гэдэг

Хипполитус – *Эгэйнст ти Хэрэйси оф уан Ноэтус* номыг бичсэн Ромын теологич (са МЭ. 170-236 он). Номондоо Бичвэр бол онол сургаалын эцсийн дээд эрх мэдэл гэдгийг хамгаалсан.

Ирениус – Хоёрдугаар зууны бишоп (са. МЭ. 130-202 он). *Гаж сургаалын эсрэг* хэмээх номдоо гностисизмыг няцааж, дөрвөн сайнмэдээний хүчинтэй байдлыг баталж бичсэн

Ислам – Мухаммедын үг ба сургаалыг баримталдаг, цорын ганц бурханд итгэгч Муслимчуудын шашин. Тэд Есүс бол Бурханы жинхэнэ эш үзүүлэгч байсан гэж итгэдэг. Гэвч тэд Есүсийг хэзээ ч загалмайд цовдлогдож, үхлээс амилаагүй гэдэг ба Түүний бурханлаг чанарыг үгүйсгэдэг

Никаиагийн тунхаг – МЭ 325 онд Никаиа хотын зөвлөлийн бичсэн тунхаг. Энэ нь Элч нарын тунхгийн дэлгэрэнгүй тайлбар бөгөөд Гурвалын онолыг баталж, Арианизмыг няцаасан байдаг

Ориген – Александриагаас гаралтай Христитгэлийн эхэн үеийн теологич (са. МЭ 185-254). Түүний бичсэн бүтээлүүдэд Бичвэр бол Христитгэлийн эцсийн дээд эрх мэдэл гэдгийг хамгаалсан *Он Фөст Принциплес* болон Хуучин Гэрээний янз бүрийн орчуулгын харьцуулсан судалгаа болох *Хексапла* зэрэг ажлууд багтдаг

Ромын тунхаг/Хуучин Ромын тунхаг – Есүсийн дараа нэгдүгээр зуунд Ромын чуулганд ашигладаг байсан тунхаг. Элч нарын тунхгийн эртний хувилбар

аврал – Есүс Христийн амьдрал, үхэл ба амилалтаар дамжуулан ёр муугийн эрхшээлээс чөлөөлөгдөж, гэм нүглийн эсрэг Бурханы шийтгэлээс өршөөгдөх явдал

сола Скрипт – “Зөвхөн бичвэр” гэсэн утгатай Латин хэллэг. Энэ нь Бичвэр бол теологийн ямар ч асуудалд эрхэм дээд, эцсийн шүүгч мөн гэсэн итгэл үнэмшил бөгөөд Шинэчлэлийн үндсэн зарчмын нэг

теологи – Бурхантай шууд холбоотой эсвэл Бурхантай холбоотой зүйлсийг тайлбарласан аливаа үзэл санаа

Гурвал– Бурхан бол цор ганц боловч гурван бодгалиар Оршигч гэдэг үнэнийг илэрхийлдэг теологийн хэллэг